



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ БАРИМТАЛЖ БУЙ
БОДЛОГО, ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨРТӨГ, ЗАРДАЛ

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/25-ШТА-ГА

ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, АЮУЛГҮЙ, ТОГТВОРТОЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРТ
ХҮРЭХИЙН ТУЛД САЛБАРЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ, ШИНЭ ТЕХНОЛОГИ
ИННОВАЦИ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖСЭНЭЭР АЛДАГДЛЫГ
БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын
захирал, тэргүүлэх аудитор **Д.Энхболд**
Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn
Аудитын менежер **Б.Батчимэг**
Утас: 261639, Цахим хаяг: batchimegb@audit.gov.mn
Ахлах аудитор С.Дарьмаа
Цахим хаяг: darimaas@audit.gov.mn
Аудитор: Д.Доржнамжим
Цахим хаяг: dorjnamjimd@audit.gov.mn
Аудитор: Н.Онон
Цахим хаяг: ononn@audit.gov.mn
Аудитор: А.Учрал
Цахим хаяг: uchrala@audit.gov.mn
Аудитор: Н.Наранзаяа
Цахим хаяг: naranzayan@audit.gov.mn
Аудитор: Н.Түмэнцэцэг
Цахим хаяг: tumentsetsegn@audit.gov.mn
Аудитор: А.Чимэгсүрэн
Цахим хаяг: chimegsurena@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалт, өртөг, зардал" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг Нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрчим хүчний зохицуулах хороо, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын баримт болон нотлох зүйлийг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын менежер (Б.Батчимэг)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.



С. МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А.1/6 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ҮНЭ ТАРИФЫН
ЗОХИЦУУЛАЛТ, ӨРТӨГ, ЗАРДАЛ АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН
АЛБАН ШААРДЛАГА

№	Хариуцагч байгууллага	Гаргасан шийдэл	Зөрчлийн тоо	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/
1	Эрчим хүчний яам	Албан шаардлага	4	Зөрчил аргилуулах тухай	-
2	Эрчим хүчний зохицуулах хороо	Албан шаардлага	4	Зөрчил арилгуулах тухай	-
3	Диспетчерийн үндэсний төв	Албан шаардлага	1	Зөрчил арилгуулах тухай	31,870.8
Нийт			9	-	31,870.8

Агуулга

Агуулга	2
Товчилсон үгийн тайлбар	3
<i>Хүснэгтийн жагсаалт</i>	4
<i>Дүрслэлийн жагсаалт</i>	5
<i>Хавсралтын жагсаалт</i>	5
Төрийн аудитын стандартын мэдэгдэл	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХҮНИЙ НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН Ч САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛД АХИЦ, ДЭВШИЛ ГАРАХГҮЙ БАЙНА.	10
<i>Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичигт тусгаагүй, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.</i>	10
<i>Эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болох арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.</i>	12
<i>Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих хяналт хангалтугүй байна</i>	16
<i>Салбарын бүтэц зохион байгуулалт, уялдаа холбоо нь үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөөлөл үзүүлэхгүй байна.</i>	24
БҮЛЭГ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФЫГ БОДИТ ӨРТГӨӨС ДООГУУР ТОГТООЖ БАЙГАА НЬ САЛБАРТ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА АЛДАГДАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.	29
<i>Эрчим хүчний салбарын алдагдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тулгамдаж байгаа хүндрэлийг бүрэн арилгах, тогтвортой үр дүнд хүрэхгүй байна.</i>	29
<i>Эрчим хүчний үнэ тарифыг тогтоохдоо “үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах” зарчмыг баримтлахгүй байна.</i>	31
<i>Импортын цахилгаан эрчим хүчний хэрэглээний хараат байдал өндөр хэвээр байгаа нь цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өсөлтөд нөлөөлж байна.</i>	35
<i>Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийн ЦЭХ-ний хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглээнд олгож буй 50 хувийн хөнгөлөлт нь тооцоо судалгаанд үндэслээгүй байна.</i>	38
<i>Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийн гарааны үнийг ТЭЗҮ-д үндэслэн тогтоож байгаа нь ЦЭХ-ний үнэ тарифыг бодитой тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.</i>	41
ДҮГНЭЛТ	48
ЗӨВЛӨМЖ	50
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛАНД ТУСГАСАН ТАЛААР: ...	52
ХАВСРАЛТУУД	53

Товчилсон үгийн тайлбар

ЭХтХ	Эрчим хүчний тухай хууль
ЭХХтХ	Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
СЭХтХ	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
ХБТТУтХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ҮТХН	Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт
МУ	Монгол Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах ажил
ГА	Гүйцэтгэлийн аудит
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ДБ	Дэлхийн банк
АХА	Америкийн хөгжлийн агентлаг
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЭХС	Эрчим хүчний систем
АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний сүлжээ
ТБНС	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ
ӨБНС	Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээ
БЗӨБЦТС	Баруун, зүүн, өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
ЭБЦТС	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
НЦС	Нарны цахилгаан станц
СЦС	Салхин цахилгаан станц
УЦС	Усан цахилгаан станц
НХА	Нэг худалдан авагчийн ашиг
НХЗ	Нэг худалдан авагчийн загвар
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
БОШХ	Борлуулалтын орлогод шаардагдах хэмжээ
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ДЭХ	Дулааны эрчим хүч
СХЧ	Суурилагдсан хүчин чадал
ЭХБББ	Эрчим хүчний барилга байгууламж барих
ТХ	Тогтвортой хөгжил
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын цахилгаан эрчим хүчний суулилагдсан хүчний чадал /МВт/	8
Хүснэгт 2	Монгол Улсын ЦЭХ үйлдвэрлэлийн хэмжээ (сая кВт.ц)	8
Хүснэгт 3	Зорилго 7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх зорилтын бэлэн байдал хангагдсан эсэх	11
Хүснэгт 4	Эрчим хүчний Трилемма (Trilemma) индекс зэрэглэлийн ба тэнцлийн оноо	12
Хүснэгт 5	Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичгүүдийн харилцан уялдааны байдал	13
Хүснэгт 6	Бодлогын баримт бичгийн үнэлгээ	15
Хүснэгт 7	“Алсан хараа-2050”-д эрчим хүчний салбарыг хэмжих шалгуур үзүүлэлт	15
Хүснэгт 8	Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ	17
Хүснэгт 9	Төслийн ерөнхий мэдээлэл	19
Хүснэгт 10	Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ	19
Хүснэгт 11	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх төсөл	20
Хүснэгт 12	Ховд нарны цахилгаан станцын нийт үр ашгийн тооцоо (2022-2024)	21
Хүснэгт 13	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тариф	23
Хүснэгт 14	СЭХ үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн эрчим хүч борлуулах үнийн мэдээлэл	24
Хүснэгт 15	Эрчим хүчний салбарын ТЗЭ-ийн эдийн засгийн үзүүлэлт (тэрбум.төг)	29
Хүснэгт 16	Эрчим хүчний ТЗЭ-ийн нийт өр, төлбөр (тэрбум.төг)	30
Хүснэгт 17	Ухаалаг тоолуурын суурилуулалт (мянга)	31
Хүснэгт 18	Эрчим хүчний салбарын ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал, тооцоо, гүйцэтгэлийн харьцуулалт (тэрбум. төг)	32
Хүснэгт 19	ТЗЭ-ийн үндсэн үйл ажиллагааны зардал, төрлөөр (тэрбум.төг)	32
Хүснэгт 20	Төрийн өмчийн ТЗЭ-ийн тарифын санал, тооцоо, гүйцэтгэлийн харьцуулалт	33
Хүснэгт 21	Эдийн засгийн зарим үзүүлэлт	33
Хүснэгт 22	ДЭХ-ний нэгжийн өртөг, борлуулсан дундаж үнэ тариф	34
Хүснэгт 23	Импортлосон ЦЭХ-ний хэмжээ, төлбөр (дүнд эзлэх хувь)	36
Хүснэгт 24	ТБНС-ний ЦЭХ-ний үйлдвэрлэл (сая.кВт.ц)	36
Хүснэгт 25	Улсын төсвөөс олгосон татаас (тэрбум.төг, хувь)	37
Хүснэгт 26	Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнэ тарифын хөнгөлөлтөд хамрагдсан айл өрх, хэрэглээ, хөнгөлөлтийн дүн	39
Хүснэгт 27	Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн хөнгөлөлтөд хамрагдсан хэрэглэгч, 2024 он	39
Хүснэгт 28	Агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж	40
Хүснэгт 29	Өвлийн хүлэмжийн хөнгөлөлтөнд хамрагдсан аж ахуй эрхлэгч, хөнгөлөлтийн дүн	40
Хүснэгт 30	Төвийн бүсийн СЭХ-ний баталсан гарааны үнэ тариф болон одоогийн хуулийн үнийн харьцуулалт	42
Хүснэгт 31	Олон Улсын болон Монгол Улсын СЭХ-ний хөрөнгө оруулалтын, үнэ тарифын харьцуулалт	43
Хүснэгт 32	ЭХЗХ-ны дотоод аудитын дүгнэлт	43
Хүснэгт 33	Санхүүгийн дэмжлэг авсан СЭХ үйлдвэрлэх ТЗЭ-дийн хөрөнгө оруулалт	43
Хүснэгт 34	Төвийн бүсийн СЦС-ын ЦЭХ үйлдвэрлэгчийн биет хэмжээг нэмэгдүүлсэн байх тооцоолол	44
Хүснэгт 35	УБЦТС ТӨХК-ийн хэрэглэгчийн ЦЭХ-ний төлбөрийн нэхэмжлэх	45
Хүснэгт 36	СЭХ-ний дэмжих тарифын гүйцэтгэл болон дундаж тарифт эзлэх хувь	45
Хүснэгт 37	ЭХБББ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглэгчийн тарифт үзүүлэх нөлөөлөл	45
Хүснэгт 38	Эрчим хүчний яамны Шилэн дансны хуулийн хэрэгжилт	47
Хүснэгт 39	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт	47

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилт	12
Дүрслэл 2	Бодлогын баримт бичгийн тоон үзүүлэлтийн харьцуулалт	14
Дүрслэл 3	ОХУ болон БНХАУ-аас импортоор худалдаж авсан цахилгааны биет хэмжээ /сая кВт.ц/	15
Дүрслэл 4	2021-2024 оны ЭХЯ-ны төсөв (тэрбум.төг, хувь)	17
Дүрслэл 5	Эрчим хүчний төсөл арга хэмжээний төсөвт өртгийн санхүүжилт	20
Дүрслэл 6	БЗӨБЦТС ТӨХК болон ЭБЦТС-ийн алдагдал	22
Дүрслэл 7	Эрчим хүч үйлдвэрлэгчидтэй байгуулсан гэрээний дүн 2024 оны байдлаар	23
Дүрслэл 8	Монгол улсын нийт борлуулсан эрчим хүч, ТБНС-ний нийт борлуулсан эрчим хүчний орлого	23
Дүрслэл 9	Эрчим хүчний салбарын ажилтны тоо болон цалингийн зардлын харьцаа	25
Дүрслэл 10	Эрчим хүчний салбарын бүтэц зохион байгуулалт	26
Дүрслэл 11	Олон улсын эрчим хүчний салбарын тогтолцоо	35
Дүрслэл 12	ТЗЭ-ийн алдагдлын өөрчлөлт, өмчийн хэлбэрээр (сая.төг)	30
Дүрслэл 13	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журмын зураглал	32
Дүрслэл 14	ЦЭХ-ний нэгжийн өртөг, борлуулсан дундаж үнэ тариф	35
Дүрслэл 15	Импортын цахилгаан эрчим хүчний оролцоо, төлбөр	36
Дүрслэл 16	ТБНС-ийн борлуулсан дундаж үнэ тариф болон импортын төлбөрийн харьцуулалт	37
Дүрслэл 17	Гэр хорооллын айл өрхөд ЦЭХ-ийн тарифын хөнгөлөлт үзүүлэх зураглал	39
Дүрслэл 18	Монгол Улсын болон СЭХ-ний СХЧ-ын үзүүлэлт (МВт)	42
Дүрслэл 19	СЭХ-ний гэрээний гарааны үнийг тооцох аргачлал дахь тарифын бүтцийн зураглал	42

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ
Хавсралт 2	1 кВт.ц ЦЭХ-ийг борлуулсан дундаж тариф, бодит өртгийн харьцуулалт
Хавсралт 3	Эрчим хүчний салбарын эдийн засгийн үзүүлэлт
Хавсралт 4	Импортын ЦЭХ-ний нэгжийн өртөг, түүний нөлөө (дүнд эзлэх хувь)
Хавсралт 5	ТЗЭ-дийн 2021-2024 онуудын ухаалаг тоолуурын судалгаа
Хавсралт 6	ЭХЗХ-ны Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Төрийн аудитын стандартын мэдэгдэл

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” шийдвэрийг үндэслэн гүйцэтгэв.
АУДИТЫН КОД	ГНАГ-2025/25-ШТА-ГА
АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	Эрчим хүчний салбарын эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байгааг судлан дүгнэлт, зөвлөмж боловсруулан зорилтот хэрэглэгчдэд хүргэхэд аудитын зорилго оршино. Үүнд: • Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудалд ахиц дэвшил гарсан эсэх; • Эрчим хүчний үнэ тариф, нийлүүлэлт нь иргэд, аж ахуй эрхлэгчдийн эрх ашигт нийцэж байгаа эсэх;
ХАМАРСАН ХҮРЭЭ	Аудитад Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Эрчим хүчний яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл, Аймаг, нийслэлд эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл болон холбогдох бусад байгууллагаас 2021-2024 онд гаргасан шийдвэр, үйл ажиллагаа баримт материал, мэдээллийг хамруулан гүйцэтгэсэн
АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Аудитад АДБОУС, Монгол Улсын төрийн аудит MNS 6817:2020 стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, бусад заавар, аргачлал, гарын авлага, удирдамжийг мөрдөж ажиллав. Аудитад дараах хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, түүнийг дагалдан гарсан дүрэм, журам, заавар, аргачлал, төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрэх үр дүнг шалгуур болгов. Үүнд: Бодлогын баримт бичгүүд: ▪ Тогтвортой хөгжлийн зорилт-2030; ▪ Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; ▪ Шинэ сэргэлтийн бодлого; ▪ Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт; ▪ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай (2024 он); ▪ Бусад холбогдох баримт бичгүүд. Хууль тогтоомж: ▪ Эрчим хүчний тухай хууль; ▪ Зөвшөөрлийн тухай хууль; ▪ Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль; ▪ Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; ▪ Төсвийн тухай хууль; ▪ Хэмнэлтийн тухай хууль; ▪ Шилэн дансны тухай хууль; ▪ Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм; ▪ Бусад холбогдох хууль тогтоомж.
АУДИТЫН БҮРЭЛДЭХҮҮН	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Батчимэг

хэрэгжүүлж, ахлах аудитор С.Дарьмаа, аудитор Д.Доржнамжим, Н.Онон,
А.Учрал, Н.Наранзаяа, Н.Түмэнцэцэг, А.Чимэгсүрэн нар гүйцэтгэв.

**АУДИТЫН
ХЯЗГААРЛАЛТ**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын эрчим хүчний салбар нь газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран Баруун, Төв, Зүүн бүс болон Алтай-Улиастайн эрчим хүчний сүлжээ гэсэн дөрвөн системээс бүрддэг бөгөөд улсын хэмжээнд цахилгаан үйлдвэрлэлийн нийт 1664.4 МВт-ын суурилагдсан хүчин чадлын 79.2 хувийг нь нүүрсээр ажилладаг дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх станц, 9.3 хувийг салхин парк, 9.4 хувийг наран цахилгаан станц, 1.6 хувийг усан цахилгаан станц, 0.5 хувийг дизель станцын эх үүсвэр бүрдүүлж, цахилгаан хангамжийн 75.4 хувийг дотоодод үйлдвэрлэж, импортоор 24.6 хувийг авч ашиглаж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчний чадал /МВт/

Эх үүсвэрийн нэр		2021	2022	2023	2024
ДЦС-ын СХЧ /МВт/		1269.0	1269.0	1269.0	1319.0
Дизель станцын СХЧ /МВт/		8.6	8.6	8.6	8.6
СЭХ СХЧ	Төвийн бүс	245.0	245.0	245.0	285.0
	Бусад	26.2	41.8	51.8	51.8
Улсын нийт СХЧ /МВт/		1548.8	1564.4	1574.4	1664.4

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл /Бөөрөлжүүтийн 150 МВт цахилгаан станц 2025 онд орсноор 1814.39МВт болно/

Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээнээс авч үзэхэд Монгол Улсын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онд 8,754.7 сая кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 226.4 сая кВт.ц-аар буюу 2.6 хувиар өссөн ба нийт цахилгааны 90.6 хувийг дулааны цахилгаан станцаар, 8.6 хувийг нар, салхины эх үүсвэрээр, 0.8 хувийг усан цахилгаан станцаар, 0.001 хувийг дизель станцаар тус тус үйлдвэрлэсэн байна.

Харин 2024 онд 2,863.3 сая кВт.ц цахилгааныг импортоор авсан нь 2023 онтой харьцуулахад 415.7 сая кВт.ц буюу 17.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Монгол Улсын ЦЭХ үйлдвэрлэлийн хэмжээ (сая кВт.ц)

		2021	2022	2023	2024
ДЦС-ын эх үүсвэр		7,109.60	7,428.50	7,755.20	7,930.60
СЭХ-ний эх үүсвэр	СЦС	563.00	508.50	531.50	517.50
	НЦС	156.90	178.70	193.00	232.30
	УЦС	83.10	61.70	48.10	74.10
Дизель станц		1.10	1.20	0.50	0.10
Импорт	ОХУ	486.80	694.30	938.00	1,319.20
	БНХАУ	1,375.10	1,467.20	1,509.70	1,544.20
		9,775.60	10,340.10	10,976.00	11,619.00

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 127¹ аж ахуйн нэгж байна. Хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан, дулааны эрчим хүчний дундаж үнэ тариф 2021-2024 онуудад бодит өртгөөс доогуур байгаа (Хавсралт 2-оос дэлгэрүүлж харна уу) нь эрчим хүчний салбарын алдагдлыг 2024 онд 229.0 тэрбум төгрөгт хүрэхэд нөлөөлж байна. Иймд эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг тогтмол хийхгүй бол тус салбарын алдагдал буурахааргүй байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлт багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 зорилт, 13 арга хэмжээ, 22 хөгжлийн төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

¹Эрчим хүчний барилга, байгууламж барих тусгай зөвшөөрөлтэй 53 аж ахуйн нэгж ороогүй.

Эдгээрийн нэг нь “Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана” гэсэн зорилт тусгагдсан бөгөөд Багануурын 50 МВт хүчин чадалтай батарей хуримтлуурын станц төвийн системд 2024 оны 12 дугаар сарын 13-наас эрчим хүч нийлүүлж эхэлсэн бөгөөд тус станц эрчим хүчний хэмнэлттэй горимоор буюу шөнийн цагт үйлдвэрлэсэн илүүдэл эрчим хүчийг хуримтлуулж, оргил цагт ачаалал хуваалцах зорилготой байна.

Хөгжлийн бүтээн байгуулалт газар зүйн бүтээн байгуулалтаар нь харуулбал.



БҮЛЭГ 1. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХҮНИЙ НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН Ч САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛД АХИЦ, ДЭВШИЛ ГАРАХГҮЙ БАЙНА.

Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичигт тусгаагүй, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

1.1. Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг 2015 оны 9 дүгээр сард баталж 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүх салбарыг тэгш хөгжүүлэхэд чиглэн хэрэгжүүлж эхэлсэн.



1.2. Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтод нэгдсэн 167 орноос зорилтын хэрэгжилтээрээ 2024 онд 99-д орсон байна. Тэгвэл “Тогтвортой хөгжил-2030” зорилтод Эрчим хүчний салбарын 5 зорилт, 6 үзүүлэлт тусгажээ.

1.3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг Монгол Улсын Их хурлын 52 дугаар тогтоолоор хүчингүй болгож, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигт эрчим хүчний асуудлыг тусгасан ч “Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийн 244 шалгуур үзүүлэлтийг харгалзаж үзээгүй байна.

Хүснэгт 3. Зорилго 7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх зорилтын бэлэн байдал хангагдсан эсэх

ТХ-2030 зорилт	Үзүүлэлт	Мэдээллийн бэлэн байдал
Зорилт 7.1 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүчний үйлчилгээгээр хүн бүрийг хангах	7.1.1 Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	●
	7.1.2 Цэвэр түлш, технологийг голчлон хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	●
Зорилт 7.2 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх	7.2.1 Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	●
Зорилт 7.3 2030 он гэхэд эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн хурдыг дэлхийн түвшинд хоёр дахин нэмэгдүүлэх	7.3.1 ДНБ, анхдагч эрчим хүчээр хэмжсэн эрчим хүчний үр ашиг	●
Зорилт 7.a 2030 он гэхэд цэвэр эрчим хүчний судалгаа шинжилгээ, технологи, түүний дотор сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, дэвшилтэт болон цэвэр хатуу түлшний технологийг хүртээмжтэй болгох үүднээс олон улсын хамтын ажиллагааг сайжруулж, эрчим хүчний дэд бүтэц, цэвэр эрчим хүчний технологид оруулах хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих	7.a.1. Цэвэр эрчим хүчний судалгаа, хөгжил, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, түүний дотор хосолмол системийг дэмжих чиглэлээр хөгжиж буй орнуудад үзүүлж буй олон улсын санхүүгийн тусламж	●
Зорилт 7.b 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй орнуудын иргэдийг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангах дэд бүтцийг өргөжүүлж, технологийг шинэчлэх	7.b.1. ДНБ-нд эзлэх эрчим хүчний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх чиглэсэн хөрөнгө оруулалт болон тогтвортой хөгжлийг дэмжсэн дэд бүтэц, технологид зориулсан санхүүжилтийг хийхэд зарцуулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ	●

Эх сурвалж: sfg.gov.mn

1.4. Олон улсын гэрээ конвенцод нэгдэх, соёрхон батлах асуудлыг УИХ бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц нь Монгол Улсын Олон улсын гэрээ болж үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчлэхийг Үндсэн хуульд заажээ.



1.5. Парисын хэлэлцээр (Paris agreement) нь 2015 онд дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ бөгөөд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцын (UN FCCC) хүрээнд хийгдсэн бөгөөд үндсэн зорилго нь дэлхийн дулаарлыг 1.5 хэмээс хэтрүүлэхгүй байх хэмжээнд тогтоон барих, үйлдвэрлэлээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын тогтвортой байдлыг хангах зорилготой.

1.6. Манай улс Парисын хэлэлцээрт 2015 оны 12 дугаар сард нэгдэн орсон бөгөөд дараах үүргийг хүлээжээ.

- Хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд **22.7** хувиар бууруулах;
- Монгол Улсын Засгийн газар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд **“Ногоон хөгжлийн бодлого”**-ын хүрээнд /2021 онд хүчингүй болсон/ сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, байгалийн нөөцийн үр ашигтай менежмент хийх, ногоон санхүүжилт татах зэрэг арга хэмжээнүүдийг дэмжих;
- Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлж, 2030 он гэхэд нийт эрчим хүчний **30** хувийг сэргээгдэх эрчим хүчнээс хангах.

1.7. Хэлэлцээрээр хүлээсэн үүргийн хүрээнд ЭХЗХ 2021 онд **“Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг тодорхойлох үндэсний арга зүй боловсруулах”** судалгаа болон арга зүйг боловсруулсан боловч батлагдаагүй байна.

1.8. Хэлэлцээрийн үндсэн зорилгын хүрээнд “Алсын хараа-2050”-д Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтыг хэрэгжүүлэх дараах 4 үйл ажиллагаа тусгасан. Үүнд:

- Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна;
- Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын уур амьсгалын ногоон сан болон бусад олон улсын санхүүгийн арга хэлбэрээр дамжуулан сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хаягдлыг багасгах, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх ногоон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд хор, нөлөөгүй үйлдвэрийг байгуулна.

1.9. Дээрх үйл ажиллагаа нь дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй нь хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, эерэг үр дүн гаргах нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Трилемма индекс

Дэлхийн эрчим хүчний зөвлөлөөс гаргадаг эрчим хүчний гурвалсан бодлого түлш, эрчим хүчний асуудлыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллөөр нь харгалзан үнэлдэг индексээр Монгол Улс 2023 оны байдлаар 76-т эрэмбэлэгдэж 2021 оноос 3 байраар ухарсан байна.

Хүснэгт 4. Эрчим хүчний Трилемма (Trilemma) индекс зэрэглэлийн ба тэнцлийн оноо

№	Чадавхын үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	Хандлага
1	Эрчим хүчний аюулгүй байдал	45.15	46.33	47.68	48.23	48.06	D
2	Эрчим хүчний хүртээмж	57.04	62.55	63.45	63.65	68.94	C
3	Байгаль орчны тогтвортой байдал	49.46	49.46	44.99	44.22	43.34	D

Эх сурвалж: trilemma.worldenergy.org

1.10. Дээрх үнэлгээнээс харахад эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой байдлыг хангах тал дээр үр дүнтэй арга хэмжээ авч чадахгүй олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

1.11. Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор **“Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”**-ыг баталсан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.12. Харин Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргийг эрчимжүүлэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны а/807 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан дараах төлөвлөгөөг боловсруулсан байна. Үүнд:

- УТХН²-ийн зорилтыг олон улсын болон үндэсний хөгжлийн бодлого. Салбарын хөтөлбөртэй уялдуулан шинэчлэх ажлын төлөвлөгөө боловсруулах;
- Салбар тус бүрд УТХН-ийн зорилтын хэрэгжилтийг хангахуйц бодлого, арга хэмжээ тодорхойлох;
- УТХН-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын боломжуудыг судлах, санхүүгийн хэрэгслүүдийг тодорхойлох;
- Парисын Хэлэлцээр болон бусад олон улсын гэрээний хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлон холбогдох талуудад танилцуулах;
- УТХН-ийн хэрэгжилтийн явц болон үр дүнгийн талаар салбар хоорондын уялдааг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ил тод байдлыг сайжруулах арга замыг боловсруулах;
- УТХН-ийн шинэчлэл болон хэрэгжилтийн явцад шаардлагатай зөвлөх, техникийн дэмжлэг авах талаар санал боловсруулах.

1.13. Иймд дээрх зорилтыг хангах ажлын төлөвлөгөөг эрчимжүүлж, "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын хүрээнд хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хангаж ажиллахад анхаарах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.14. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг батлахдаа Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, мэдээллийн бэлэн байдал хангагдаагүйгээс үнэлэх боломжгүй, салбарын хүрээнд дэлхийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, өнөөгийн байдал, хүрсэн түвшин, тулгамдаж буй асуудал, дэвшүүлсэн зорилгодоо хүрч бодлогын үр нөлөөг гаргах боломжийг бүрдүүлж чадахгүй байна.

Эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болох арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.15. Засгийн газрын 2018 оны 325 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого 2015-2030” баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбоотой 2021 оны 89 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон хэдий ч, “Алсын хараа-2050”-ыг боловсруулахад суурь баримт бичиг болгон ашиглажээ.

1.16. “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого 2015-2030”-ыг 6 зорилгын хүрээнд 27 зорилт, 100 арга хэмжээ төлөвлөж 70.8 хувийн хэрэгжилттэй (тодорхой үр дүнд хүрсэн) гэж Засгийн газар үнэлсэн байна.

1.17. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын I үе шат (2021-2030)-д эрчим хүчний талаар 4 зорилтын хүрээнд 20 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дүрслэл 1. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилт



Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно



Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

Зорилт 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.

² Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт

**Орчин төвтэй шийдэл**

Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

**Төлөвлөлт төвтэй хөгжил**

Зорилт 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.

Эх сурвалж: www.legalinfo.mn

1.18. Эрчим хүчний салбарт дараах бодлогын баримт бичгүүд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд зорилт, үйл ажиллагаа арга хэмжээ нь агуулгын хувьд уялдаж байгаа ч ангилал, эрэмбэ дараалал, ач холбогдол, хэрэгжүүлэх хугацаагаар уялдахгүй байна.

Хүснэгт 5. Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичгүүдийн харилцан уялдааны байдал

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-2030 5 зорилт 6 үзүүлэлт	АЛСЫН ХАРАА - 2050 4 зорилт 20 үйл ажиллагаа	ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО 5 зорилт 13 үйл ажиллагаа	МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 6 зорилт 18 арга хэмжээ	МУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР 8 зорилт 39 арга хэмжээ
Зорилт 7.1	2.5.4.	2.1.	4.2.7.	3.5.1.
Зорилт 7.2	4.2.1.	2.2.	4.2.8.	3.5.2.
Зорилт 7.3	4.2.7.	2.3.	4.2.11.	3.5.3.
Зорилт 7.a	4.2.8.	2.4.	4.2.12.	3.5.4.
Зорилт 7.b	4.2.34.	2.5.	4.2.14.	3.5.5.
	4.2.35.		4.2.16.	3.5.6.
	4.2.36.			3.5.7.
	4.2.37.			4.5.3.
	4.2.38.			
	4.2.40.			
	4.2.41.			
	4.2.42.			
	4.6.6.			
	9.3.36.			
	9.3.47.			

Эх сурвалж: www.legalinfo.mn, www.unelgee.gov.mn

1.19. Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилтын хүрээнд дунд болон богино хугацааны үйл ажиллагаа арга хэмжээг төлөвлөхдөө чанарын болон тоон үзүүлэлтийг харгалзаагүй байна.

Дүрслэл 2. Бодлогын баримт бичгийн тоон үзүүлэлтийн харьцуулалт



Эх сурвалж: www.legalinfo.mn

1.20. Эрчим хүчний салбарт баримтлах бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж үзэхэд “Шинэ сэргэлтийн бодлого”-**2**, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-**5**, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-**3**, Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс-**4** төсөл арга хэмжээ хоорондоо уялдаагүй байна. Үүнд:

Шинэ сэргэлтийн бодлого	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө
- Эгийн голын усан цахилгаан станцын биологийн олон янз байдлын нөлөөллийн судалгааг дуусгаж, Дэлхийн өвийн хороонд хүргүүлэх - Өмнийн говийн нар салхины эх үүсгэврийг ашиглаж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх судалгаа хийх	- Эрчим хүчний сүлжээнд ашиглах том хэмжээний хуримтлуурын төсөл - Оюу толгой Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Концессын эргэн төлөлт/ - Увс аймгийн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам барих төсөл - Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Тэвшийн говийн цахилгаан станц төсөл - Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Концессын эргэн төлөлт/	- Төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. - Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ. - Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ.	- 10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх - Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих - Шинэ нисэх-Зуунмод сумыг холбосон 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 дэд станц байгуулах ажлыг үргэлжлүүлэх - Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 МВт-аар өргөтгөх

1.21. ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5³-д “10 жилийн хугацаанд хэрэгжих бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна” гэж тодорхойлсон ч уялдаа холбоогүй төлөвлөлтөөс бодлогын зорилго, зорилт хангагдахгүй, зарим төсөл арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж байна.

1.22. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрээс доош чиглэсэн, салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн саналыг нэгтгэн доороос дээш чиглэсэн нэгдмэл уялдаа холбоотой байхаар төлөвлөх шаардлагатай байна.

³ Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна:

Бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний үнэлгээний талаар

1.23. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай бодлогын баримт бичиг нь 2024 оны 6 дугаар сард батлагдсан бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулан үнэлэн жилд нэг удаа төрийн захиргааны төв байгууллагад тайлагнахаар тусгагдсан бөгөөд 2024 оны байдлаар 33.8 хувиар үнэлсэн байна.

1.24. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 30 жилийн хугацаанд 9 зорилго, 47 зорилт, 73 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тусгаснаас эрчим хүчний талаар бодлогын баримт бичигт сүүлийн 3 жилд дараах байдлаар үнэлсэн байна.

Хүснэгт 6. Бодлогын баримт бичгийн үнэлгээ

№	Бодлогын баримт бичиг	Үнэлгээ		
		2022	2023	2024
1	Алсын хараа-2050	50.8%	-	-
2	Шинэ сэргэлтийн бодлого /Эрчим хүчний сэргэлт/	-	-	33.8%
3	Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл /ЭХЯ/	60%	78%	52.9%
4	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр			70.8%
5	Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө /ЭХЯ/		60.7%	48.2%
6	Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /ЭХЯ/			82.27%

Эх сурвалж: www.unelgee.gov.mn, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт аудитын тайлангаас

1.25. Харин “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Бүс орон, нутгийн хөгжил” 8 дугаар бүлгийн зорилгод хүрэх үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Хүснэгт 7. “Алсан хараа-2050”-д эрчим хүчний салбарыг хэмжих шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин		
				2025	2030	2050
1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	-	95.5	100	100

Эх сурвалж: www.legalinfo.mn

1.26. Эрчим хүчний талаар Монгол улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд хийсэн аудитын дүгнэлтэд улсын хэмжээний цахилгааны нийт түгээлт 10,589.9 сая.кВт.цаг байгаа ба дотоодын эх үүсвэрээс 7,750.2 сая.кВт.цаг түгээлт хийж, цахилгаан эрчим хүчийг дотоодоос 73.1 хувиар хангасан гэж дүгнэжээ.

1.27. Монгол улс 2021-2024 онд импортоорс **2,422.1 тэрбум төгрөгийн** цахилгаан эрчим хүч худалдан авсан байна.

Дүрслэл 3. ОХУ болон БНХАУ-аас импортоор худалдаж авсан цахилгааны биет хэмжээ /сая кВт.ц/

2021 он	2022 он	2023 он	2024
• 1,861.9	• 2,161.5	• 2,447.7	• 2,864.3

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

1.28. Импортоор худалдаж авсан цахилгаан эрчим хүч 2020 оныг 2024 онтой харьцуулахад **59%-иар** өссөн байх бөгөөд “Алсын хараа-2050”-д Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхэд чиглэсэн **импортын эрчим хүчний хараат байдлыг бууруулах** зорилтын биелэлт хангагдахгүй, бусад тэргүүлэх салбарын зорилтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Эрчим хүч хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангуулах уялдаа холбоо бүхий үндэсний хэмжээний бодлого шаардлагатай байна.

1.29. Эрчим хүч хэмнэлтийн талаар “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”-үүд 2021 онд хүчингүй болсон.

1.30. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9.1.10⁴-д “эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах” гэж, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн I-р үе шат 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 9.3.36-д “Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тусгасан байна.

1.31. Засгийн газрын 2017 оны 274 тогтоолоор 18 зорилт, 87 арга хэмжээг аймаг нийслэлийн улсын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байсан ч 2021 онд хүчингүй болгожээ.

1.32. Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 1.4-т “Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэгтэй Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл (цаашид “Хэмнэлтийн зөвлөл” гэх)-ийн бүрэн эрхийг Хороо хэрэгжүүлнэ” гэж тусгаснаас гадна хорооны бүтцэд Хэмнэлтийн газар байгаа ч хууль тогтоомжид тусгасан үндэсний хэмжээний хөтөлбөр баталж хэрэгжүүлээгүйд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

1.33. Мөн Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд “Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох”, “Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангиал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ыг баталж хэрэгжүүлэх зохицуулалттай ч батлагдаагүй байна.

1.34. Эрчим хүч хэмнэлтийн талаар дан ганц хуулиар зохицуулсан үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах нь хангалттай биш харин салбар хоорондын уялдаа холбоог хангасан үндэсний хэмжээний эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх нь чухал байна.

Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт, үр ашгийг нэмэгдүүлэхэд тавих хяналт хангалтгүй байна

1.35. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, эдийн засаг, хүний эрх гэсэн үндсэн дөрвөн салбарын 16 чиглэлийн 620 зорилт тусгаснаас эрчим хүчний салбарын асуудлыг эрчимжүүлэх хүрээнд дараах 3 мега төслийг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

Төслийн нэр	Зорилго
Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц.	Төслийн хүчин чадал 90 МВт 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун 5 аймгийн 253.3 сая кВт.ц хэрэглээ болон тус бүс нутгийн өсөн нэмэгдэх хэрэгцээг хангана.
Эгийн голын 315 мВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц.	Төслийн суурилагдсан хүчин чадал 315 МВт, төсөл хэрэгжсэнээр 500 орчим ажлын байр бий болж импорт экспортын цахилгаан эрчим хүчний урсгалыг зохицуулж, эрчим хүчний өөрийн өртөг буурна.
Таван толгойн дулааны цахилгаан станц.	Тухайн станц нь бүрэн ашиглалтад орсноор Монгол Улсын Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 1.88 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх ба 220 байнгын ажлын байр бий болж, 120-140 сая ам.доллар гадагш чиглэсэн валютын урсгалыг дотооддоо үлдээж, 34.5 сая ам.долларын татварын орлого бүрдүүлнэ.

⁴ 9.1.10.эрчим хүчний хэмнэлтийн бодлого, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт тайлагнах;

Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх төсөл.


Төсөл хэрэгжсэнээр 0.04-0.05 ам.доллар хямд үнэ бүхий цэвэр эрчим хүчээр хангах ба түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 586.5 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг салхин станц 693.6 мянган тонн, нарны цахилгаан станц 244.8 мянган тонноор тус тус бууруулна.

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

1.36. Эрчим хүчний сайдын 2021-2024 оны нийт батлагдсан төсөв 935.3 тэрбум төгрөг байгаагаас урсгал зардал 421.3 тэрбум (улсын төсвөөс компаниудад олгосон санхүүгийн дэмжлэг, татаас 390.1 тэрбум), хөрөнгийн зардал 513.9 тэрбум төгрөг байгааг харьцуулан дараах зураглалаар харуулж байна.

1.37. Үзүүлэлтээс харахад эрчим хүчний салбарын алдагдал түүнд олгож буй улсын төсвийн дэмжлэг, татаас нь 2021-2024 оны ЭХЯ-ны нийт төсвийн 42.0 хувийг эзэлж байгаа нь тухайн салбарын томоохон төслүүдэд хийх хөрөнгө оруулалтын санхүүжилтэд ач холбогдол өгөхгүй байгаа нь харагдаж байна.

Дүрслэл 4. 2021-2024 оны ЭХЯ-ны төсөв (тэрбум.төг, хувь)



Эх сурвалж: Аудитын баг

1.38. Мөн Эрчим хүчний салбарт оруулж буй дэмжлэг, татаас болон төрийн оролцоо, алдагдлын хэмжээ өндөр байгаа нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломжийг хязгаарлаж байна.

1.39. Эрчим хүчний салбарт баримтлах бодлогын хүрээнд 2021-2024 оны хооронд 38 арга хэмжээнд нийт 9,378.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 4,990.9 тэрбум төгрөг буюу 53.0 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 4,387.5 тэрбум төгрөг буюу 47.0 хувийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 8. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ, тэрбум төгрөг	Хүрэх зорилго 2021-2024 онд
1	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц	2021-2026	818.5	80%
2	160 МВт.ц багтаамжтай	2021-2023	292.7	100%
3	Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц	2020-2021	146.7	100%

4	Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц	2021-2023	3.7	-
5	10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барина	2020-2023	422.6	100%
6	Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах	2021-2025	125.9	100%
7	Улаанбаатарын хотын дулаан хангамж төслийг хэрэгжүүлнэ	2021-2024	23.4	100%
8	Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах	2017-2022	156.0	100%
9	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлнэ	2020-2023	66.4	100%
10	Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам,	2021-2023	180.5	100%
11	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	2020-2024	172.1	100%
12	Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл	2022-2025		
Нийт төсвийн дүн			2,408.6	

Эх сурвалж: Аудитын баг

1.40. Дээрх төслөөс бүрэн хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн эерэг үр дүнгээс дурдвал Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц 71 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай, 67 МВт хүртэл ачаалал авах 3-4 МВт нөөцтэй, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 2.4 дахин өсгөж, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртгийг багасгасан үр өгөөж бий болгосон байна.

1.41. Харин Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц нь 2024 онд төслийн гүйцэтгэгч компани өөрсдийн хөрөнгөөр барилга угсралтын ажил хийж гүйцэтгэсэн байна. Үүнд төслийн талбарт байнгын ажлын байр, ажиллагсдын сууц, бетон зуурмагийн үйлдвэр, гаалийн баталгаат агуулах, барилга угсралтын ажлыг цахилгаан хангамж, зам гүүрний ажлыг гүйцэтгэсэн байна. Төсөл арга хэмжээний санхүүжилт шийдвэрлэж 2025 оноос төслийг гүйцэтгэх ажил эхлээд байна.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд

1.42. Манай улсад зээл, тусламжийн харилцааг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-аар тус тус зохицуулж байна.

1.43. Эрчим хүчний салбарт гадаад зээлийн санхүүжилтээр 7, буцалтгүй тусламжаар 4, буцалтгүй тусламж болон зээлээр 5, техник туслалцааны 3, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй 1 нийт 20 төслийн талаар Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу өрийн мэдээллийн нэгдсэн сан буюу www.odamis.mof.gov.mn-д бүртгэсэн байна.

1.44. Дээрх 20 төслөөс зээлээр санхүүжих 11 төслийн 6 нь амжилттай, 2 нь хэрэгжээгүй, 3 нь гүйцэтгэлийн шатанд байгаа бол буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн 9 төслийн 2 нь хэрэгжиж байгаа, 1 төсөл хэрэгжээгүй, 3 нь гүйцэтгэлийн явцтай, 3 нь техник туслалцаагаар хэрэгжүүлсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-ээс харна уу

1.45. Төслийг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл дулаан хангамжийн 4, цахилгаан дамжуулах шугам сүлжээний 7, сэргээгдэх эрчим хүчний 3, эрчим хүчний 2, техник туслалцааны 3, сайн засаглал 1 төсөл хэрэгжиж байна.

1.46. Тайлангийн 1.41-т дурдсан цахим системд 20 төсөл бүртгэлтэй тухай дурдсан бол Эрчим хүчний яаманд 7 төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл, бүртгэлд байхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангасан, хариуцлагатай байх зарчимд нийцэхгүй байна.

1.47. Эрчим хүчний яамны шилэн дансны бүртгэлд хэрэгжиж буй 13 төсөл хөтөлбөрийн мэдээллийг байршуулахаас 10 төслийн мэдээллийг байршуулсан бол “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх, Сэргээгдэх эрчим хүчний

халаалтын системийн туршилтын төсөл мэдээлэл байхгүй, Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төсөл"-ийн мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

1.48. Энэ нь “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 11.12⁵-т заасантай нийцээгүй бөгөөд тухайн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтэд тавих хяналт, хангалтгүй байгааг харуулж байна. (албан шаардлага)

1.49. Эрчим хүчний салбарт хийгдэж буй дараах 5 томоохон төслийн гүйцэтгэл удааширсан нь чиг үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоо бүрэн хангагдаагүй, шийдвэр гаргахад хугацаа алдах, хоцрох, өртөг зардал нэмэгдэх эрсдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 9. Төслийн ерөнхий мэдээлэл

№	Төслийн нэр	Хэрэгжүүлэх огноо	Төсөл удааширсан шалтгаан
1	Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл	2018-2024 он	Зээлийн хэлэлцээр удааширсан
2	Эгийн голын усан цахилгаан станц төсөл	-	Сэлэнгэ мөрний сав газрын нарийвчилсан судалгаа, нөлөөлөх байдлын үнэлгээ болон урсцын хэмжээг тохируулах байгууламжийн ТЭЗҮ боловсруулах
3	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл	2020-2023 он	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авалт хугацаандаа хийгдээгүй
4	Тавантолгой дулааны цахилгаан станц төсөл	2013-2023 он	Төслийг хэрэгжүүлэх нөхцөл өөрчлөгдсөн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шалгаруулалт амжилтгүй болсон
5	10 аймгийн дулааны цахилгаан станц төсөл	2019-2024 он	Зээлийн ашиглалт хугацаандаа хийгдээгүйгээс төслийн өртөг нэмэгдсэн, гүйцэтгэгч санхүүгийн хүндрэлтэй байдалд орсон.

Эх сурвалж: Төслийн нэгжийн тайлан, Сангийн яамны Odamis цахим нэгдсэн мэдээллийн сангийн мэдээлэл.

1.50. Эрчим хүчний яам нийт 11,150.89 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 11 арга хэмжээг зохих түвшинд хэрэгжүүлэн 9,172.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ огт хэрэгжээгүй байна

Хүснэгт 10. Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний төлөв	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /тэрбум төгрөг/
1	Хэрэгжиж дууссан 100% гүйцэтгэлтэй ТАХ	7	1,309.5
2	Хэрэгжиж байгаа 70% гүйцэтгэлтэй ТАХ	2	160.2
3	Эрчимжүүлэх шаардлагатай 30% гүйцэтгэлтэй ТАХ	2	509.0
4	Хэрэгжээгүй 0% гүйцэтгэлтэй ТАХ	7	9,172.2

Эх сурвалж: Аудитын баг

1.51. Дээрх төлөвлөлт, хэрэгжилтээс үзэхэд төслүүдийг ач холбогдлоор эрэмбэлж, судалгаа шинжилгээ, нарийвчилсан төлөвлөгөө, санхүүжилтийн эх үүсвэртэй нь уялдуулан төсвийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

1.52. Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий томоохон төслүүдийг Эрчим хүчний яам удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналтыг тогтмол хэрэгжүүлснээр санхүүжилтийг үр ашигтай ашиглаж, төсөл хугацаандаа хэрэгжих нөхцөл бүрдэхээр байна.

⁵ 11.12. Төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөл, арга хэмжээний тайлан, мэдээг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тухай бүр оруулна.

Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн судалгаа, тооцоолол хийгдэж байна

1.53. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдөр баталсан бөгөөд өнөөдрийн байдлаар 2 төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

1.54. ЭХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.19⁶-д заасны дагуу ЭХЯ нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, төвийн бүсийн эрчим хүчний системд горим тохируулгын дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах хоёр төслийг санаачлан ЭЗХЯ-тай хамтран төсөлд иж бүрэн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах бүрэлдэхүүнийг байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 11. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх төсөл

№	Төслийн нэр	Захиалагч болон гүйцэтгэгч
1	Байдрагийн усан цахилгаан станц төсөл	ЭХЯ, БХБЯ
2	Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт-ын усан цэнэгт цахилгаан станц" төсөл	ЭХЯ, БХБЯ

Эх сурвалж. Эрчим хүчний яам

1.55. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хэрэглээний өсөлтийг хангахад нар, салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа боловч цаг хугацаа, цаг агаараас хамааран тогтворгүй, хувьсан өөрчлөгдөж байдгаас гадна оргил ачааллын үед нарны эх үүсвэрүүд оролцох боломжгүй, салхины эх үүсвэр хязгаартай оролцдог хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Импортын эрчим хүчийг багасгах,⁷
- Сэргээгдэх эрчим хүчний нар, салхины эх үүсвэрүүдийн хэлбэлзлийг тохируулах,
- Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний балансыг тогтворжуулах,
- Уян хатан системийг хөгжүүлэх зорилгоор ус хуримтлуурт усан цахилгаан станц болон Монгол Улсын дотоодын урсгалтай голуудад бага, дунд чадлын усан цахилгаан станцуудыг барьж байгуулах.

1.56. Эрчим хүчний салбарт 2021-2025 онд төлөвлөсөн төслийн нийт төсөвт өртөг 11,150.0 тэрбум төгрөг байгаагаас 10,400.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл тусламжаар шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.

Дүрслэл 5. Эрчим хүчний төсөл арга хэмжээний төсөвт өртгийн санхүүжилт



Эх сурвалж: Аудитын баг

⁶ Эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам батлах

⁷ Төвийн бүсийн эрчим хүчний системд горим тохируулгын түргэн маневрлах цахилгаан станцгүй тул ОХУ-ын Буриадын эрчим хүчний системтэй 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар эрчим хүч импортлож горимын тохируулгаа хийж чадлын дутагдлаа нөхдөг бөгөөд сүүлийн жилүүдийн хэрэглээний өсөлтөөс шалтгаалан тус дамжуулах шугамаар авах чадлын дээд хязгаар 315 МВт хүрч ачаалал тулсан.

1.57. Улсын Их Хурлын 2009 оны 64 дүгээр тогтоолоор “төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг баталж “дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, нэгдсэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх” гэх зорилт дэвшүүлсэн байна.

1.58. Өнөөдрийн байдлаар эрчим хүчний салбарт баримтлах бодлого, хууль эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

Салбарын хэмжээнд техникийн шинэчлэлийн ажлыг тогтмол зохион байгуулах хэрэгцээ шаардлага өндөр байна

1.59. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах, түгээх үйл ажиллагааны техникийн алдагдлыг бууруулах зорилтын хүрээнд *Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл, Эрчим хүч-2* зэрэг төслүүдийг дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна.

1.60. *Эрчим хүч-2 төслийн* хүрээнд Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (БЗӨБЦТС), Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ (ЭБЦТС) ТӨХК-ийн харьяа Багануур дүүрэг, 10 аймгийн төв, бүх сумын төвийн түгээх сүлжээний техникийн шинэчлэлийн ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгчээ.

1.61. Тухайн төслийн хүрээнд хуучирч ашиглалтаас гарсан тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулах шугамыг өргөтгөж шинэчилснээр, шинээр хэрэглэгч холбох, хэрэглэгчдийг аюулгүй, найдвартай, стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах боломжтой болжээ.

1.62. Мөн Ховд аймгийн Мянгад суманд 10МВт-ын нарны цахилгаан станц барьж ашиглалтад оруулснаар 2022-2024 оны хооронд 57.9 сая.кВт.ц цахилгаан эрчим хүчийг ББЭХС-д нийлүүлж мөн хэмжээгээр импортоор авах эрчим хүчний биет хэмжээг бууруулсан байна.


Хүснэгт 12. Ховд нарны цахилгаан станцын нийт үр ашгийн тооцоо (2022-2024)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт
1	НЦС-ын үйлдвэрлэсэн	мян.кВт.ц	58,677.10
2	Системд нийлүүлсэн	мян.кВт.ц	57,943.68
3	ОХУ-аас худалдан авсан бол	Рубль	233,606.46
4	Монгол төгрөгөөр	сая.төг	10,026.75
5	Нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын бууралт	тонн/сар	46,765.65

Эх сурвалж: Аудитын баг

1.63. Эрчим хүчний төсөл 2-ын хүрээнд ЭБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 1.3 хувиар, нийт алдагдал 3 хувиар, БЗӨБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 0.8 хувиар, нийт алдагдал 2.7 хувиар тус тус буурсан бол 14 аймгийн хэмжээнд нийт 69,279 ширхэг ухаалаг тоолуур байршуулсан нь тухайн түгээх компаниудын арилжааны болон зүй бус алдагдлыг бууруулахад томоохон түлхэц болсон байна.

Дүрслэл 6.БЗӨБЦТС ТӨХК болон ЭБЦТС ТӨХК-ийн алдагдал



Эх сурвалж: Аудитын баг

1.64. Эрчим хүчний төсөл 2- ыг хэрэгжүүлснээр төрийн өмчийн түгээх чиг үүргийн 3 компанийн алдагдал, импортын эрчим хүчийг бууруулах чиглэлд ахиц гарч байгаа нь салбарын хэмжээнд техникийн шинэчлэлийн ажлыг тогтмол зохион байгуулах хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

1.65. Харин Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хувьд Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан боловч олон улсын зөвлөх компанийг сонгон шалгаруулах, нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил удааширч төслийн хэрэгжих хугацаа 2026 он болж хойшилсон байна.

Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нэмэгдэж, нийт хэрэглээний 9 хувийг нэгдсэн сүлжээнд үйлдвэрлэн нийлүүлж байгаа ч өртөг өндөр байна.

1.66. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.2.37-д “Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэх, гадагш урсгалтай гол, мөрний урсацын 10 хувийг эрчим хүчний үйлдвэрлэл болон бусад хэрэгцээнд ашиглана” гэж тусгажээ.

1.67. 2024 оны байдлаар эрчим хүчний салбарын нийт суурилагдсан хүчин чадал 1,814.4 МВт байгаагаас 336.84 МВт буюу 18.6 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд эзэлж байна (дэлгэрэнгүйг дүрслэл 18-аас харна уу).

1.68. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 90.9 хувийг дулааны цахилгаан станцаар, 8.5 хувийг нар, салхины эх үүсвэрээс, 0.6 хувийг усан цахилгаан станцаар, 0.01 хувийг дизель станцаар тус тус үйлдвэрлэсэн байна.

1.69. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээс эрчим хүч нийлүүлэх гэрээний үнийн дүнг валютаар тооцдог нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэл болон орлогын харьцааг алдагдуулж байна.

1.70. СЭХТХ-ийн 11 дүгээр зүйлд “нар, салхи, усан цахилгаан станцуудын тарифыг ам доллар”-оор тогтоосны дагуу гэрээ байгуулж байгаа нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1⁸ д заасантай зөрчилдөж байна. Хуульд дараах байдлаар эрчим хүчний үнийн хязгаарыг тогтоосон байна.

⁸ 4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.

Хүснэгт 131. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тариф

№	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний үнэ, тариф	
1	Салхин цахилгаан станц	1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.085 ам.доллар хүртэл
2	Усан цахилгаан станц	1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам.доллар хүртэл
3	Нарны цахилгаан станц	1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.12 ам.доллар хүртэл.

Эх сурвалж: www.legalinfo.mn

1.71. СЭХ-ний эх үүсвэрээс эрчим хүч худалдан авах гэрээний үнийг валютаар тооцож байгаа нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2-д "үнэ, тариф нь хэрэглэгчдийн худалдан авах чадавхад нийцсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

1.72. Эрчим хүч үйлдвэрлэгч нартай байгуулсан гэрээний дүнг харьцуулж үзэхэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн тариф ам.доллороос төгрөгт шилжүүлэн тооцоход дунджаар 1кВт.цаг 371.13 төгрөг, дулааны цахилгаан станцын дундаж тариф 1кВт.цаг 120.72 төгрөг буюу сэргээгдэх эх үүсвэрээс 3.2 дахин бага байна.

Дүрслэл 7. Эрчим хүч үйлдвэрлэгчидтэй байгуулсан гэрээний дүн, 2024 оны байдлаар



Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр
1кВт.цаг -ийн дундаж үнэ 371.13 төгрөг




Уламжлалт эх үүсвэр бүхий ДЦС
1кВт.цаг -ийн дундаж үнэ 120.72 төгрөг

Эх сурвалж. ЭХЗХ-ны статистик мэдээ, 2024 он

1.73. Эрчим хүчний системд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн нийлүүлж байгаа сэргээгдэх эрчим хүчний станцууд нь валютаар эрчим хүч худалдаж байгаа нь цаашдаа эрчим хүчний биет хэмжээ нэмэгдэхгүй боловч нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний төлбөр валютын ханшны өсөлтөөс шалтгаалан жил бүр нэмэгдэхээр байна.

Дүрслэл 8.Монгол улсын нийт борлуулсан эрчим хүч, ТБНС-ний нийт борлуулсан эрчим хүчний орлого



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

1.74. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэж буй эрчим хүчний биет хэмжээ нэмэгдэхгүй, харин валютын өсөлттэй холбоотойгоор эрчим хүчний системээс авах төлбөр нь өсөн нэмэгдэж байгаа нь үйлдвэрлэл болон орлогын зөрүүтэй байдлыг үүсгэж байгааг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 14. СЭХ үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн эрчим хүч борлуулах үнийн мэдээлэл

№	Үзүүлэлт	ЦЭХ худалдан авсан үнэ /төг кВт.ц/			2023 онд нийлүүлсэн ЦЭХ-ний биет хэмжээ	
		2022 он	2023 он	Зөрүү	/сая.кВт.ц /	/тэрбум төгрөг/
1	Клин энерги ХХК	300.76	329.14	28.38	159.7	4.5
2	Клин энерги Ази ХХК	299.1	325.22	30.04	181.0	5.4
3	Сайншанд салхин парк ХХК	302.22	328.91	26.69	184.4	4.9
4	Соларповер интернэйшнл ХХК	520.1	567.46	47.36	16.4	0.8
5	Эвридэй ферм ХХК	545.11	599.8	54.69	17.5	1.0
6	Нарантээг ХХК	483.53	530.09	46.56	24.7	1.1
7	И Эс Би Солар Энержи ХХК	545.55	597.98	52.43	18.9	1.0
8	Тэнүүн гэрэл констракшн ХХК	510.19	561.7	51.51	28.1	1.5
9	Дезерт солар пауэр вуан ХХК	447.1	492.26	45.16	51.0	2.3
Нийт дүн						22.5

Эх сурвалж. ЭХЗХ-ны мэдээлэл

1.75. Дээрх тооцооллоос үзэхэд СЭХ-ний үйлдвэрлэлийн валютын ханшны өсөлтөөс шалтгаалж 22.5 тэрбум төгрөгийн тарифын зөрүү үүссэн байна.

Салбарын бүтэц зохион байгуулалт, уялдаа холбоо нь үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөөлөл үзүүлэхгүй байна

1.76. Эрчим хүчний яам 2025 оны байдлаар 110 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. 2016-2025 оны хооронд “Эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын шийдвэрээр нийт 4 удаа өөрчлөлт хийжээ. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоол /8 дугаар хавсралт/
- Засгийн газрын 2019 оны 375 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020 оны 94 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2023 оны 197 дугаар тогтоол

1.77. Эрчим хүчний яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталдаг ч хэрэгжилт хангагдсан эсэх нь тодорхойгүй байна. Иймд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

1.78. Шинэчлэн баталсан Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор эрчим хүчний салбарын бүтцийг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тусгаж диспетчерийн зохицуулалт хийх, үйлдвэрлэх, дамжуулах, түгээх/хангах төрийн өмчит нийт 18 хувьцаат компани байгуулсан.

1.79. Энэхүү өөрчлөлтөөр Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, хангах талд өрсөлдөөн бий болгох зорилгоор үйлдвэрлэгч буюу станцуудыг, мөн цахилгаан түгээх сүлжээг бие даасан төрийн өмчит компани болгон зохион байгуулжээ.

1.80. 2024 оны байдлаар Төрийн өмчит компанийн 41 хувийг Дэд бүтцийн яам, 39.0 хувийг Төрийн өмчийн хороо, 20.0 хувийг Сангийн яам тус тус эзэмшдэг байсан бол 2016 оноос хувьцааны 70.0 хувийг Эрчим хүчний яам, үлдсэн 30.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

1.81. Төрийн өмчит компанийн засаглалын тогтолцоо, удирдлагын шийдвэр гаргалт нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагаас бүрдэж, Эрчим хүчний яам, ТӨБЗГ-аас төрийн өмчийг төлөөлөх этгээдийг томилж, чөлөөлж, удирдамж хүргүүлж байна.

1.82. Өнөөдрийн байдлаар 32 ТӨХК байгаагаас 27 нь ТУЗ- тэй бөгөөд дараах оролцоог ханган ажиллаж байна.

Компанийн түвшинд	Төлөөлөн удирдах зөвлөл	Эрчим хүчний яам
Бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний төслийг боловсруулна. Үүнд: • Зохион байгуулалтын бүтэц • Орон тоо, цалингийн сан /батлагдсан зорилтот түвшинд үндэслэн тогтооно/ • Удирдлагын зардал	Бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний төслийг дэмжинэ. Үүнд: • Орон тоо, цалингийн сан • Удирдлагын зардал • Зохион байгуулалтын бүтцийг батална	Бизнес төлөвлөгөө, зорилтот түвшнийг батална. Үүнд • Орон тоо, цалингийн сан • Удирдлагын зардал


Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

1.83. Төрийн өмчит компанийн бүтэц орон тоо жилээс жилд нэмэгдэж байгаа боловч Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн зүгээс сайн засаглалыг бий болгож, өөрийн үйл ажиллагааны зохион байгуулалтаар үр дүнг дээшлүүлж, ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй ажиллах байдал хангалтгүй байна.

1.84. Салбарын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөхийн хэрээр хүний нөөц нэмэгдэж түүнд зарцуулах төсөв өссөн нь салбарын хэмжээнд эрчим хүчний нэгжийн өртөг зардал өсөх нэг хүчин зүйл болж байна.

1.85. Салбарын хэмжээнд 2019-2024 оны хооронд нийт цалин жил бүр дунджаар 21.4 хувиар өсөж, салбарын ажиллагсдын тоо өндөр хэвээр байгааг дараах дүрслэлээс харна уу.

Дүрслэл 9. Эрчим хүчний салбарын ажилтны тоо болон цалингийн зардлын харьцаа



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл


1.86. ЭХЗХ-ны даргын 2019 оны А/03 дугаар тогтоолоор “Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг оновчтой тогтоох аргачлал (жишиг нормативын төсөл)” боловсруулах ажлын хэсэг байгуулан судалгаа хийж, санал боловсруулсан боловч ЭХЯ хуулиар олгосон бүрэн эрхийн⁹ хүрээнд тодорхой арга хэмжээ аваагүй байна.

1.87. 2021 онд хийгдсэн Эрчим хүчний дамжуулалт, түгээлт, үнэ тарифын зохицуулалт, үр нөлөө сэдэвт гүйцэтгэлийн аудитаар “Хөдөлмөрийн бүтээмжээс хамаарсан бүтэц, орон тоог тогтоох жишиг норм нормативыг баталж мөрдөх” тухай зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй байна.

⁹ 6.1.9.эрчим хүчний нөөцийн үнэлгээ хийх журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж хэрэгжүүлэх; 6.1.10.эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах;

Дүрслэл 10. Эрчим хүчний салбарын бүтэц зохион байгуулалт

Эрчим хүчний салбарын өнөөгийн бүтэц зохион байгуулалт




Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

1.88. Олон улсад эрчим хүчний салбар дараах 4 хэлбэрийн бүтэц, тогтолцоотой байдаг бол судалгаанд хамрагдсан нийт 113 орноос нэгдсэн босоо бүтэцтэй 32, улсын хэмжээнд үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт хангах нэгдсэн 14, станцуудаар нь задалсан, дамжуулах, түгээлт, хангах нь нэгдсэн 12, бүх үйл ажиллагаа нь задарсан 55 орон байна.

1.89. Харин Монгол Улс үйлдвэрлэл, дамжуулалт нь бие даасан, түгээлт, хангалт нь нэгдмэл бүтцээр ажилладаг байна.

Дүрслэл 11. Олон улсын эрчим хүчний салбарын тогтолцоо



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Тайлбар: Дугуй дүрс нь дамжуулалт, түгээлт, хангах нь нэг гэдгийг харуулж байна.

1.90. Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаар, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн аюулгүй, найдвартай, үр ашигтай ажиллагааны шаардлагад нийцүүлэхээр 4 удаагийн ажлын хэсэг байгуулагдаж байсан. Үүнд:

- Эрчим хүчний сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 201 дүгээр тушаал
- Эрчим хүчний сайдын 2020 оны 68 дугаар тушаал
- ЭХЯ-ны 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар
- ЭХЗХ-ны даргын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/44 тоот тушаал

1.91. Дээрх ажлын хэсгийн дүгнэлтэд одоогийн байгаа бүтэц нь санхүү эдийн засгийн хувьд дараах давуу болон сул талуудтай гэж дүгнэснийг аудитын асуудлын хүрээнд шалгаж үзэхэд:

Давуу тал	Аудитын асуудлын хүрээнд илэрсэн нөхцөл байдал
Хөрөнгө оруулагчдын оролцоо Үйлдвэрлэх (бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч), хангах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн болон гаднын хөрөнгө оруулагчийн оролцоог бий болгох суурь нөхцөлийг (менежментийн гэрээ) бүрдүүлсэн;	Эрчим хүчний салбарт оруулж буй дэмжлэг, татаас болон төрийн оролцоо, алдагдлын хэмжээ өндөр байгаа нь гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломжийг хязгаарлаж байна. (Тайлангийн 1.38-1.41-ээс харна уу)
Компанийн шийдвэр гаргах үйл явц Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах үйл явц илүү шуурхай, харьцангуй бие даасан байдлаар явагдах боломжтой болсон;	Шийдвэр гаргах үйл явц илүү шуурхай, харьцангуй бие даасан байдлаар явагдах боломжтой болсон ч гэсэн дорвитой ахиц гараагүй, компани бүр төлөөлөн удирдах зөвлөлтэй, олон тооны гүйцэтгэх удирдлагатай байснаар үргүй зардал гарч байна. (Тайлангийн 1.79-1.88-аас харна уу)
ТЗЭ компаниуд хоорондын арилжааны үйл ажиллагаа Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ТЗЭ компаниуд хоорондын арилжааны төлбөр тооцооны үйл ажиллагаа нь ил тод, боловсронгуй болж, гэрээгээр хүлээх хариуцлага сайжирч компани хоорондын шууд хөндлөн татаас байхгүй болсон;	- Арилжааны төлбөр тооцооны нөхцөлийг гэрээгээр зохицуулдаг ба тухайн жилийн эцэст ЭХЗХ-оос санхүүгийн тоо мэдээг нэгтгэн тайлагнадаг байна. - Дулааны борлуулалтын дундаж үнэ үйлдвэрлэх, дамжуулах, түгээх зардал буюу нэгжийн өртгөөс 2024 оны байдлаар 35.3 хувиар доогуур байгаа нь нэгж өртөг, дундаж тарифын зөрүүгээс үүссэн алдагдлыг цахилгааны борлуулалтын орлогоос хөндлөн татаасаар нөхдөг. (Тайлангийн 1.79-1.88-аас харна уу)
Эрчим хүчний орлого төвлөрүүлэлт Хэрэглэгчдэд борлуулсан эрчим хүчний орлогыг цаг тухайд нь бүрэн төвлөрүүлэх хариуцлага, хөшүүрэг бий болсон;	Эрчим хүчний салбарын нийт ТЗЭ-ийн 2024 оны үйл ажиллагааны орлого нь 2021 онтой харьцуулахад 47.0 хувиар, салбарын үйл ажиллагааны алдагдал (СЭХ ороогүй дүн) нь 2.9 дахин өссөн байна. (Тайлангийн 2.01-2.10-аас харна уу)
Сул тал	Аудитын асуудлын хүрээнд илэрсэн нөхцөл байдал
Санхүү, эдийн засгийн хүрээнд - Босоо бүтцээс хэвтээ бүтцэд шилжсэнээр эрчим хүчний зах зээл, компанийн засаглалын үйл ажиллагаанд дорвитой ахиц гараагүй; - Компани бүр төлөөлөн удирдах зөвлөлтэй, олон тооны гүйцэтгэх удирдлагатай байснаар үргүй зардал гарах, улс төрийн нөлөөлөлд өртөх магадлал өндөртэй болсон; - Олон жижиг компаниуд бий болсон нь үргүй зардлыг нэмэгдүүлж салбарын хэмжээгээр эрчим хүчний нэгжийн өртөг зардал өсөх нэг хүчин зүйл болсон; - Компанийн бүтэц, орон тооны жишиг норм норматив байхгүйн улмаас хөдөлмөрийн бүтээмжээс үл хамааран орон тоо жил бүр өсөн нэмэгдэж, компанийн түвшинд удирдлага, инженер техникийн ажилтан, ажилчин, албан хаагчдын орон тооны зохистой харьцаа алдагдаж, үйл ажиллагааны өртөг зардал нэмэгдсэн;	- Салбарын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөхийн хэрээр хүний нөөц нэмэгдэх түүнд зарцуулах төсөв зарцуулалт нэмэгдэж байгаа нь салбарын хэмжээнд эрчим хүчний нэгжийн өртөг зардал өсөх нэг хүчин зүйл болж ажиллах хүчний нөөц 2019-2024 оны хооронд 71 хувиар, цалингийн зардал 44 хувиар тус тус өссөн байна. (Тайлангийн 1.84-1.92-оос харна уу) - Олон улсын түвшинд хийсэн харьцуулалтаас харахад Монгол улс холимог тогтолцооноос шилжих шаардлагатайг харуулж байна. (Тайлангийн 1.89-1.92-оос харна уу)

Компаниуд нь хөрөнгө оруулалтын ажлыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхгүй байгаагаас санхүү хөрөнгийн эх үүсвэрийг үр ашиггүй зарцуулдаг;	• Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрээс доош чиглэсэн, салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн саналыг нэгтгэн доороос дээш чиглэсэн нэгдмэл уялдаа холбоотой байхаар төлөвлөх шаардлагатай байна. (Тайлангийн 1.20-1.23-оос харна уу)
• Үйлдвэрлэгч бүр тусдаа ажиллаж байгаа тул эрчим хүчний системийн хэмжээнд хамгийн бага өртгийн зарчмаар эх үүсвэрүүдийг ачаалах, үр ашигтай горимоор ажиллуулах боломжийг хязгаарлаж байгаа;	• Тухайлбал сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нэмэгдэж, нийт хэрэглээний 9 хувийг нэгдсэн сүлжээнд үйлдвэрлэн нийлүүлж байгаа ч өртөг өндөр байна. (Тайлангийн 1.66-1.76-аас харна уу) • Импорттоор худалдаж авсан цахилгаан эрчим хүч 2020 оныг 2024 онтой харьцуулахад 59%-аар өссөн байна. (Тайлангийн 1.27-1.29-өөс харна уу)
Тасралтгүй, найдвартай ажиллагааны хүрээнд • Салбарын компаниудын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт тодорхойгүй, хоорондын уялдаа холбоо хангалтгүй;	• Бодлогын баримт бичгүүдийн зорилт, үйл ажиллагаа арга хэмжээ нь агуулгын хувьд /бүрэн/ уялдаж байгаа ч ангилал, эрэмбэ дараалал, ач холбогдол, хэрэгжүүлэх хугацаагаар уялдаж чадахгүй байна. (Тайлангийн 1.15-1.23-аас харна уу)
• Техник технологийг шинэчлэх нэгдсэн бодлого алдагдсан; • Салбарын хэмжээнд техникийн төлөв байдал, ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаанд тавих техник хяналтын нэгдсэн тогтолцоогүйгээс их, урсгал засварын чанар хангалтгүй	• ЭБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 1.3, нийт алдагдал 3 хувиар, БЗӨБЦТС ТӨХК-ийн техникийн алдагдал 0.8 хувиар, нийт алдагдал 2.7 хувиар тус тус буурсан бол 14 аймгийн хэмжээнд нийт 69,279 ширхэг ухаалаг тоолуур байршуулсан нь тухайн түгээх компаниудын арилжааны болон зүй бус алдагдлыг бууруулахад түлхэц болсон ч сүүлийн жилүүдэд томоохон хэмжээний техникийн шинэчлэл хийгдээгүй байна. (Тайлангийн 1.59-1.65-аас харна уу)
• Салбарын хэмжээнд сахилга хариуцлага суларсан, осол, аваар, саатал гарсан шалтгааныг бодитой тодорхойлох, түүний мөрөөр авах арга хэмжээ, буруутай этгээдэд хариуцлага тооцох асуудал хангалтгүй; • Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнүүдэд төлөвлөгөөт засвар хийх графикийг харилцан уялдуулдаггүйгээс хэрэглэгчдийг эрчим хүчээр удаа дараа хязгаарлахад хүрдэг; • Томоохон аваар, саатал гарах үед бүс нутгийн компаниудад хөрөнгө санхүү, мэргэжлийн боловсон хүчин, машин механизм, сэлбэг хэрэгсэл хангалтгүй байгаагаас сэргээн засварлах ажлыг бие даан гүйцэтгэх чадавхгүй тул төвийн бүсийн компаниудыг дайчлан, төлөвлөгөөт бус зардлыг нэмэгдүүлж байгаа;	

1.92. Дээр харьцуулалтаас үзэхэд тулгамдаж буй асуудалд бодитоор хандаж шийдвэрлээгүй, зах зээлийн зарчмыг хязгаарлаж, эрчим хүчний салбарт ахиц дэвшил гараагүй нь харагдаж байна.

1.93. Эрчим хүчний салбарын тогтолцоо нь сул талууд ихтэй байгаад зохих арга хэмжээ авахгүй бол салбарын өсөлт хөгжил, өрсөлдөх чадварыг бууруулах, эрсдэлтэй байна.

БҮЛЭГ 2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФЫГ БОДИТ ӨРТГӨӨС ДООГУУР ТОГТООЖ БАЙГАА НЬ САЛБАРТ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА АЛДАГДАХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.

Эрчим хүчний салбарын алдагдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тулгамдаж байгаа хүндрэлийг бүрэн арилгах, тогтвортой үр дүнд хүрэхгүй байна.

2.1. Монгол Улсын эрчим хүчний салбарт 2024 оны байдлаар 180 ТЗЭ үйл ажиллагаа явуулж байгаагийн 127 буюу 70.6 хувь нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, зохицуулалтаар хангах, 53 буюу 29.4 хувь нь эрчим хүчний барилга байгууламж барих үйл ажиллагаа эрхэлж байна.

2.2. Эрчим хүчний салбарын нийт ТЗЭ-ийн 2024 оны үйл ажиллагааны орлого нь 2021 онтой харьцуулахад 47.0 хувиар өссөн ч салбарын үйл ажиллагааны алдагдал (СЭХ ороогүй дүн) нь 2.9 дахин өссөн байна. Цахилгаан, дулааныг борлуулсан дундаж үнэ тариф эрчим хүчний нэгжийн бодит өртгөөс бага байгаа нь салбарын үйл ажиллагааны алдагдлыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлж байна.

Хүснэгт 125. Эрчим хүчний салбарын ТЗЭ-ийн эдийн засгийн үзүүлэлт (тэрбум. төг)

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2024/2021	
						Тоо	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	1,388.5	1,452.3	1,848.4	2,041.5	653.0	147.0%
2	Үйл ажиллагааны зарлага	1,403.2	1,576.8	1,866.0	2,182.5	779.4	155.5%
3	НХА-ын ашиг, алдагдал	2.3	-2.2	7.0	-	-	-
4	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	-12.3	-126.7	-10.5	-141.1	128.7	1145.4%
5	Үйл ажиллагааны ашиг, алдагдал (СЭХ ороогүй)	-77.8	-187.3	-98.0	-229.0	151.2	294.3%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Тайлбар: Импортын төлбөр ороогүй

2.3. ЭХЗХ нь салбарын алдагдлыг бууруулах хүрээнд цахилгаан, дулааны эрчим хүчийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах үнэ тарифыг 2022 онд шинэчлэн баталсан. Энэ үнэ тарифын өөрчлөлтийн улмаас салбарын үйл ажиллагааны алдагдал 2023 онд 98.0 тэрбум төгрөг болж 89.3 тэрбум төгрөг буюу 52.3 хувиар буурсан байна.


2.4. Гэсэн хэдий ч тус үнэ тарифыг индексжүүлж 2023 онд шинэчлээгүйн улмаас салбарын үйл ажиллагааны алдагдал 2024 онд 229.0 тэрбум төгрөг болж 2023 оныхоос 130.9 тэрбум төгрөг буюу 2.3 дахин нэмэгдсэн байна.

2.5. Тус салбарын үйл ажиллагааны алдагдлын (СЭХ ороогүй дүнгээр) 192.3 тэрбум төгрөг буюу 84.0 хувь нь төрийн өмчийн, 21.9 тэрбум төгрөг буюу 9.6 хувь нь орон нутгийн өмчийн, 14.7 тэрбум төгрөг буюу 6.4 хувь нь хувийн өмчийн ТЗЭ-чид байна. Эндээс харахад төрийн өмчийн ТЗЭ-чид хамгийн их алдагдалтай ажиллаж иржээ.

2.6. Санхүүгийн хүндрэлтэй төрийн болон орон нутгийн өмчийн 24 ТЗЭ-дэд Төсвийн тухай хуулийн 2024 оны тодотголоор 131.0 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон нь салбарын үйл ажиллагааны алдагдлыг 35.6 хувиар бууруулж 229.0 тэрбум төгрөгт хүргэжээ¹⁰. Энэхүү санхүүгийн дэмжлэг нь салбарын үйл ажиллагааны алдагдлыг бууруулахад чиглэсэн нэг удаагийн арга хэмжээ болсон байна.

¹⁰ Эрчим хүчний сайдын 2024 оны А/200, А/221, А/309, А/310 дугаар тушаал

Дүрслэл 12.ТЗЭ-ийн алдагдлын өөрчлөлт, өмчийн хэлбэрээр (тэрбум. төг)



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.7. Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны алдагдлыг тогтвортой бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэхгүй байгаа нь тус салбарын эргэн төлөгдөх эх үүсвэргүй өр төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

2.8. Эрчим хүчний салбарын нийт өр төлбөрийн хэмжээ 2024 онд 2,690.3 тэрбум төгрөг болж 2021 оныхоос 625.1 тэрбум төгрөг буюу 30.3 хувиар нэмэгдэхэд богино хугацаат өр төлбөрийн хэмжээ 77.4 тэрбум төгрөг буюу 27.2 хувиар, урт хугацаат өр төлбөр 547.6 тэрбум төгрөг буюу 30.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ. Харин хэрэглэгч, харилцагчдаас авах авлага 164.8 тэрбум төгрөгт хүрч 2021 оныхоос 38.6 тэрбум төгрөг буюу 19.0 хувиар буурчээ.

Хүснэгт 16. Эрчим хүчний ТЗЭ-ийн нийт өр, төлбөр (тэрбум.төг)

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2024/ 2021	
						Тоо	Хувь
	Нийт	2,065.2	2,171.6	2,369.3	2,690.3	625.1	130.3%
1	Богино хугацаат өр төлбөр (ТЗЭ хоорондын тооцоог цэвэрлэсэн дүн)	285.4	361.2	285.1	362.9	77.5	127.2%
2	Урт хугацаат өр төлбөр (Санхүүгийн тайлангаар)	1,779.9	1,810.4	2,084.2	2,327.4	547.6	130.8%
3	Хэрэглэгч, харилцагчдаас авах авлага (ТЗЭ хоорондын тооцоог цэвэрлэсэн дүн)	203.4	159.0	154.2	164.8	-38.6	81.0%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.9. Нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний үнэ тарифыг өөрчилж 2024 оны 11 дүгээр сард баталсантай холбогдуулан Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Шарын гол ХК- ийн нүүрсний үнийг 53.2-65.3 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн нь тэдгээр уурхайнуудын борлуулалтын орлого 449.8 тэрбум төгрөгт хүрч 1.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан эерэг нөлөө үзүүлсэн байна.

2.10. Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ийг хэрэгжүүлж, шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг хийж 45.6 сая.кВт/цаг цахилгаан эрчим хүчийг хэмнэн 31.7 тэрбум төгрөгийн үр ашгийг бий болгосон. Мөн ухаалаг тоолуурын суурилуулалт 2021-2024 онд 10.2-35.6 хувь болсон байна. Эдгээр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь эрчим хүчний салбарын техникийн болон техникийн бус алдагдлыг бууруулахад тодорхой нөлөө үзүүлжээ (Дэлгэрэнгүйг Хавсралт 5-ээс харна уу).

Хүснэгт 17. Ухаалаг тоолуурын суурилуулалт (мянга)


№		2021	2022	2023	2024
1	Суурилуулахаар төлөвлөсөн ухаалаг тоолуурын тоо	885.5	907.0	949.4	997.0
2	Суурилуулсан ухаалаг тоолуурын тоо	90.7	133.1	182.7	355.1
3	Цаашид суурилуулах шаардлагатай ухаалаг тоолуурын тоо	794.8	773.8	766.7	641.9
4	Суурилуулалтын хувь	10.2%	14.7%	19.2%	35.6%

Эх сурвалж: ЭХЗХ-ний мэдээлэл

Эрчим хүчний үнэ тарифыг тогтоохдоо “үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах” зарчмыг баримтлахгүй байна.

2.11. ЭХЗХ нь ЭХТХ-иар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”, “ТЗЭ-ийн тарифын саналыг хянах, шалгах журам” (Дүрслэл 1), “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”-ыг ТЗЭ-ийн үйл ажиллагааны бодит өртөг зардлыг тогтоох үйл ажиллагаанд мөрдөхөөр баталжээ.

Дүрслэл 13. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журмын зураглал



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.12. ТЗЭ-ийн тарифын саналыг хянах, шалгах журмаар ТЗЭ-ийн тарифын санал, түүнд тавигдах шаардлага, холбогдох баримт бичиг, материал, тоо мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийх, хянах хугацаа, тарифын саналыг шийдвэрлэх зэрэг оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан боловч хөндлөнгийн хяналт хийх үйл явцын зохицуулалтгүй байна.

2.13. ЭХЗХ нь ТЗЭ-ийн үнэ, тарифыг тогтоох, хяналтыг сайжруулах зорилгоор зохицуулалтын ахлах аудитор, аудиторыг 2024 оноос эхлэн томилон ажиллуулж байна.

2.14. Дээрх журам, зохицуулалтын аудиторуудын чиг үүрэгт тарифын аргачлал, тооцооллод хөндлөнгийн хяналт хийх зохицуулалтыг тодорхой тусгаагүй нь үнэ тарифын аргачлал, тооцооллын үнэн бодит байдалд хэрэглэгчдийн итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2.15. “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ын 2.1¹¹-д заасны дагуу тарифын саналын тооцооллыг ТЗЭ-ийн сүүлийн 3 жилийн бодит өртөг, зардлын гүйцэтгэлд

¹¹ 2.1. ТЗЭ-ийн тарифыг сүүлийн 3 жилийн бодит өртөг зардлын гүйцэтгэлд үндэслэн, зардлын бодит хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан жил бүр хянан тогтооно.

үндэслэн түлшний зардал, цалингийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусад гэсэн бүрэлдэхүүн зардлаар тооцож байна.

2.16. Нийт ТЗЭ-ийн 2024 оны тарифын саналын дүн нь 2,437.2 тэрбум төгрөг ба тус саналыг ЭХЗХ нь 294.5 тэрбум төгрөг буюу 12.0 хувиар бууруулж тооцсон. Харин ТЗЭ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 2,452.2 тэрбум төгрөг байгаа нь ЭХЗХ-ны тооцсон тарифаас 309.0 тэрбум төгрөг буюу 14.4 хувиар илүү байна. Энд ТЗЭ-ийн 2024 оны үйл ажиллагааны бодит зардал нь тарифын саналаас 15.0 тэрбум төгрөг буюу 0.6 хувиар илүү гүйцэтгэлтэй гарчээ.

2.17. Эрчим хүчний зохицуулах хороо нь ийнхүү тарифын саналыг бууруулан тооцож байгаа нь ЭХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2.1-д заасан үйл ажиллагааны бодит өртөг зардалд тулгуурлан үнэ тарифыг тогтоох зарчимтай нийцэхгүй байна.

Хүснэгт 18. Эрчим хүчний салбарын ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал, тооцоо, гүйцэтгэлийн харьцуулалт (тэрбум. төг)

№	Үнэ тариф	2021	2022	2023	2024
1	ТЗЭ-ийн тарифын санал	1,483.4	1,656.2	2,088.1	2,437.7
2	ЭХЗХ-ны тооцсон тариф	1,367.8	1,509.1	1,983.5	2,143.2
3	Тарифын санал болон тооцооны зөрүү	115.5	147.1	104.6	294.5
	Хувь	-7.8%	-8.9%	-5.0%	-12.0%
4	ТЗЭ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл	1,537.8	1,772.9	2,111.1	2,452.2
5	Гүйцэтгэл болон тооцооны зөрүү	170.0	263.8	127.5	309.0
	Хувь	-12.4%	-17.5%	-6.4%	-14.4%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.18. Эрчим хүчний салбарын ТЗЭ-ийн үйл ажиллагааны 2024 оны зардал 2021 оныхоос 751.0 сая төгрөг буюу 60.8 хувиар нэмэгдэхэд цалингийн зардал 302.3 тэрбум төгрөг буюу 79.6 хувь, түлшний зардал 189.2 тэрбум төгрөг буюу 57.7 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 193. ТЗЭ-ийн үндсэн үйл ажиллагааны зардал, төрлөөр (тэрбум.төг)

№	Зардлын төрөл	2021	2022	2023	2024	2024/2021	
						Тоо	Хувь
1	Түлшний зардал	328.1	365.9	475.4	517.3	189.2	157.7%
2	Цалингийн зардал	379.7	429.2	524.7	682.0	302.3	179.6%
3	Элэгдэл	254.7	273	282.3	301.3	46.6	118.3%
4	Бусад зардал	273.3	320.6	393.2	486.2	212.9	177.9%
	Нийт	1,235.8	1,388.7	1,675.6	1,986.8	751.0	160.8%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Тайлбар: Импортын төлбөр, СЭХ-ний төлбөр ороогүй дүн

2.19. Төрийн өмчийн 24¹² ТЗЭ-ийн 2024 оны тарифын саналыг ЭХЗХ нь 327.5 тэрбум төгрөг буюу 19.0 хувиар бууруулж 1,394.7 тэрбум төгрөг байхаар тооцсон. Харин ЭХЯ нь тэдгээр ТЗЭ-ийн тарифын саналыг 16.9 тэрбум төгрөг буюу 1.0 хувиар нэмэгдүүлэн 1,739.1 тэрбум төгрөг байхаар баталжээ (Хүснэгт 18).

2.20. Үүнээс дүгнэхэд ЭХЗХ нь жилийн үйлдвэрлэл хэрэглээний саналд үндэслэн эрчим хүчний салбарын дараа жилийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тооцоолон төрийн өмчит ТЗЭ-ийн үйл ажиллагааны орлогын саналыг (1,394.7 тэрбум.төг) ЭХЯ-нд хүргүүлж байна. Харин ЭХЯ тухайн ТЗЭ-ийн үйл ажиллагааны зардлыг орлогоос нэмэгдүүлэн (1,739.1 тэрбум.төг) зөрүүтэй зорилтод түвшин баталж байна.

¹² ЭХЯ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Монгол-Оросын Улаанбаатар төмөр зам ХНН, Хөтөл Энержи дулаан ТӨХХК, Замын-Үүдийн дулааны станц ТӨҮГ-ын БОШХ (зорилтот түвшинг)-г баталдаггүй.

2.21. Энэ нь ЭХЗХ тарифын өөрчлөлтийг үйл ажиллагааны зардалд нөлөөлөх хүчин зүйлд үндэслэн үнэ тарифыг индексжүүлэх журмын 3.1¹³ дэх хэсгийг баримталж ажиллахгүй байгааг харуулж байна. Энэ нь салбарын алдагдалд шууд нөлөөлж байна.

Хүснэгт 20. Төрийн өмчийн ТЗЭ-ийн тарифын санал, тооцоо, гүйцэтгэлийн харьцуулалт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024
1	ТЗЭ-ийн тарифын санал	тэрбум. төг	953.1	1186.7	1422.5	1722.2
2	ЭХЗХ-ны тооцсон тариф	тэрбум. төг	895.5	978.0	1240.4	1394.7
3	ЭХЯ-ны баталсан зорилтот түвшин	тэрбум. төг	973.9	1208.1	1487.1	1739.1
4	ТЗЭ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл	тэрбум. төг	1,003.3	1,109.6	1,360.4	1,624.6
	Зөрүү					
5	ЭХЗХ-ны тооцсон тариф болон ТЗЭ-ийн тарифын саналын зөрүү	тэрбум. төг	-57.6	-208.7	-182.1	-327.5
		Хувь	6.0	17.6	12.8	19.0
6	ТЗЭ-ийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл болон ТЗЭ-ийн тарифын санал	тэрбум. төг	50.2	-77.1	-62.1	-97.6
		Хувь	5.3	-6.5	-4.4	-5.7
7	ЭХЯ-ны баталсан зорилтот түвшин болон ТЗЭ-ийн тарифын санал	тэрбум. төг	20.8	21.4	64.6	16.9
		Хувь	2.2	1.8	4.5	1.0

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.22. Эрчим хүчний зохицуулах хороо нь ТЗЭ-ийн тухайн жилийн тарифыг өмнөх жилийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд үндэслэн тогтоож байна. Тухайлбал, төрийн өмчит 24 ТЗЭ-ийн 2023 оны үйл ажиллагааны зардал буюу 1,360.4 тэрбум төгрөгийг 2.5 хувиар нэмэгдүүлж, 2024 оны тарифыг 1,394.7 тэрбум төгрөг байхаар тооцжээ.

2.23. Хэрэглээний үнийн улсын индекс (инфляц) нь 2024 онд 9.0 хувь, цахилгаан, хий агааржуулалтын салбарт ажиллагсдын сарын дундаж цалин нь 2023 онтой харьцуулснаар 30.2 хувиар нэмэгдсэн байна.

2.24. ЭХЗХ нь ТЗЭ-ийн 2024 оны тарифыг 2023 оны жилийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд үндэслэн тооцож байгаа нь эдгээр өөрчлөлт, нөлөөллийг¹⁴ бодитой тусган тооцоогүйг харуулж байна.

2.25. Эрчим хүчний үнэ тариф бодит өртгөөс бага байгаа нь салбарын алдагдалд нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байна. Түүнчлэн ТЗЭ-ийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлах, дэд бүтцийн хөгжил, технологийн шинэчлэлтийг саатуулж байна.

Хүснэгт 21. Эдийн засгийн зарим үзүүлэлт

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	Жилийн дундаж өсөлтийн хувь
1	Хэрэглээний үнийн улсын индекс (2020=100) хувь	13.8	13.2	7.9	9.0	10.98
2	Цахилгаан, хий, агааржуулалтын салбарын сарын дундаж цалин (мян.төг)	1,603.3	1,815.2	2,245.08	2,923.7	-
3	Цахилгаан, хий, агааржуулалтын салбарын сарын дундаж цалингийн өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь	102.8%	113.2%	123.7%	130.2%	117.5%

Эх сурвалж: www.1212.mn

2.26. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 632–643 дугаартай 12 тогтоолоор Нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны эрчим хүчний шаталсан бүтэцтэй дундаж үнэ тарифыг баталсан.

¹³ 3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас үл хамааран эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах зардалд нөлөөлөх хүчин зүйлд үндэслэн эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлнэ.

¹⁴ Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журмын 2.1.3 хэсэг "Хэрэглээний үнийн индексийн нөлөөллийг үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл болон ажиллагсдын нийгмийн зардлыг тооцоход;"


2.27. Уг тогтоолд заасны дагуу “индексжүүлсэн” боловч бодит тооцоонд хэрэглээний үнийн индекс, валютын ханш зэргийн нөлөөллийг тусгаагүй нь шаталсан бүтэцтэй үнэ тарифын тооцооллын зардалд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан бүрэн индексжүүлээгүй байна.

Монгол улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний үнэ тариф бодит өртгөөс 26.69 төг.кВт.ц доогуур, бүсийн хувьд харилцан адилгүй байна.

2.28. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, зохицуулалтаар хангах тусгай зөвшөөрөлтэй 127 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны өртөг, зардлыг холбогдох хүчин зүйлсийн нөлөөллөөр индексжүүлээгүй нь 1 кВт.ц ЦЭХ-ийг хэрэглэгчдэд борлуулсан дундаж үнэ тариф бодит өртгөөс доогуур байх, мөн ЦЭХ-ний үндсэн үйл ажиллагааны алдагдал 2021-2024 онд 57.6-216.1 тэрбум төгрөг байхад шууд нөлөөлж байна (Дүрслэл 14, Хавсралт 4).

2.29. Тухайлбал, улсын хэмжээнд 1 кВт.ц ЦЭХ-ийг борлуулсан дундаж үнэ тариф нь 2024 онд бодит өртөг (нэгжийн өртөг)-өөс 26.69 төг/кВт.ц-аар доогуур (бага) байгаа нь ЦЭХ-ний үндсэн үйл ажиллагааны алдагдлыг 216.1 тэрбум төгрөг (үйл ажиллагааны бус орлого, үйл ажиллагааны бус зардал ороогүй) болоход нөлөөлсөн байна (Дүрслэл 11, Хавсралт 2).

Дүрслэл 124. ЦЭХ-ний нэгжийн өртөг, борлуулсан дундаж үнэ тариф



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.30. ТБНС-ний хувьд 2024 оны байдлаар ДЭХ-ний борлуулсан дундаж үнэ тариф нь нэгжийн өртгөөс 19.19 мян.төг/Гкал буюу 35.3 хувиар бага, ДБХЭС-ийн хувьд 11.2 мян.төг/Гкал буюу 37.0 хувиар бага байгаа нь салбарын алдагдлыг нэмэгдүүлж байна (Хүснэгт 20).

2.31. Дулаан эрчим хүчний нэгжийн өртөг, борлуулсан дундаж тарифын зөрүүгээр үүссэн алдагдлыг цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого (хөндлөн татаасаар)-оос нөхөж байна. Тухайлбал, 2024 оны байдлаар ТБНС-ний хөндлөн татаасын хэмжээ 170.4 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 22. ДЭХ-ний нэгжийн өртөг, борлуулсан дундаж үнэ тариф

№	Бүс	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024
1	ТБНС	ДЭХ-ний нэгжийн өртөг	мян.төг/Гкал	45,83	48,82	58,11	54,37
2		ДЭХ-ний борлуулсан дундаж үнэ тариф	мян.төг/Гкал	28,81	29,78	33,52	35,18
3		Зөрүү	мян.төг/Гкал	-17,02	-19,04	-24,59	-19,19
			Хувь	37,1	39,0	42,3	35,3

1	ДБЭХС	ДЭХ-ний нэгжийн өртөг	мян.төг/Гкал	36,13	39,28	18,13	30,25
2		ДЭХ-ний борлуулсан дундаж үнэ тариф	мян.төг/Гкал	13,44	14,52	18,13	19,05
3		Зөрүү	мян.төг/Гкал	-22,69	-24,77	-	-11,20
			Хувь	62,8	63,0	-	37,0

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.32. Дулаан эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөгт нь хүргэх зорилгоор Нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд (үйлдвэр, аж ахуйн нэгж, айл өрх) борлуулах дулааны тарифыг 2025 оны 5 дугаар сарын 16-аас мөрдөхөөр ЭХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 01- ний өдрийн 639–643 дугаар хүртэл 5 тогтоолоор баталсан боловч Засгийн газрын 132 дугаар тогтоолоор хэрэгжилтийг хязгаарласан байна.

2.33. Энэ нь ЭХЗХ-ны баталсан ашгийн зохих түвшин хангасан дулааны эрчим хүчний үнэ, тарифыг мөрдөж ажиллахад хөндлөнгөөс нөлөөлж байгааг харуулж байна.


2.34. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифын саналыг хянаж, тооцохдоо эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах зардлыг ЭХЗХ-ны 2018 оны 221 дүгээр тогтоолоор баталсан “Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам”-ын 2.1¹⁵ дэх хүчин зүйлсийн нөлөөллөөр индексжүүлэхгүй байгаа нь эрчим хүчний салбарын бодит өртгийг тооцож тарифыг батлахгүй байхад нөлөөлж байна.

Импортын цахилгаан эрчим хүчний хэрэглээний хараат байдал өндөр хэвээр байгаа нь цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өсөлтөд нөлөөлж байна.

2.35. Монгол Улс 2024 оны байдлаар ЦЭХ үйлдвэрлэлийн 2.9 тэрбум кВт.ц-ийг импортолсон нь ЦЭХ-ний үйлдвэрлэлийн 24.6 хувийг эзэлж, үүнийг 2021 онтой харьцуулахад 5.6 нэгж хувь, 2022 оныхоос 3.7 нэгж хувь, 2023 оныхоос 2.3 нэгж хувиар тус тус нэмэгдсэн (Дүрслэл 12).

2.36. Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын эх үүсвэрүүд дангаараа хангах боломжгүй, суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн үр дүн удаашралтай байх зэрэг үндсэн шалтгааны улмаас импортолсон ЦЭХ-ний хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байна. Тухайлбал, 2024 онд импортоор авсан ЦЭХ-ний төлбөрт 705.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь 2021 онтой харьцуулахад 301.6 тэрбум төгрөг буюу 74.7 хувиар нэмэгджээ.

Дүрслэл 135. Импортын цахилгаан эрчим хүчний оролцоо, төлбөр



Эх үүсвэр: ЭХЗХ-ны мэдээлэл

2.37. Улсын хэмжээнд 2024 онд нийт импортолсон ЦЭХ-ний 1.3 буюу 46.1 хувийг ОХУ-аас авч 246.8 тэрбум төгрөгийг, 1.5 тэрбум буюу 53.9 хувийг БНХАУ-аас хэрэглэж, 458.4 тэрбум

¹⁵ Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан дараах зардлуудыг индексжүүлнэ.

төгрөгийг төлж, үүнээс Оюутолгой ХХК нь 1.4 тэрбум кВт.ц ЦЭХ-ийг хэрэглэж, 431.8 тэрбум төгрөгийг зарцуулсан нь БНХАУ-аас авсан ЦЭХ-ний нийт импортын төлбөрийн 94.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 234. Импортлолсон ЦЭХ-ний хэмжээ, төлбөр

№	Импортын эх үүсвэр	2021		2022		2023		2024	
		Биет хэмжээ сая кВт.ц	Төлбөр тэрбум.төг	Биет хэмжээ сая кВт.ц	Төлбөр тэрбум.төг	Биет хэмжээ сая кВт.ц	Төлбөр тэрбум.төг	Биет хэмжээ сая кВт.ц	Төлбөр тэрбум.төг
1	ОХУ-аас авсан	486.8	105.6	694.3	187.4	938.0	213.3	1,320.1	246.8
2	ТБНС-ний импортын хэрэглээ	332.8	83.2	509.6	154.3	731.9	178.3	1,089.2	207.5
3	Дүнд эзлэх хувь	68.36	78.84	73.40	82.35	78.03	83.56	82.51	84.08
4	БНХАУ-аас авсан	1,375.1	381.2	1,467.2	430.0	1,509.7	482.7	1,544.2	458.4
5	Оюутолгой ХХК-ийн хэрэглээ	1,338.7	373.0	1,425.9	419.6	1,434.7	464.8	1,453.0	431.8
6	Дүнд эзлэх хувь	97.35	97.86	97.19	97.57	95.03	96.28	94.09	94.21
7	Нийт	1,861.9	486.8	2,161.5	617.4	2,447.7	696.1	2,864.3	705.1

Эх үүсвэр: ЭХЗХ-ны мэдээлэл

2.38. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний импортын хэрэглээ 2021 онд нийт ЦЭХ үйлдвэрлэлийн 4.8 хувийг эзэлж байсан бол 2024 онд 13.0 хувь болж нэмэгдсэн байна (Хүснэгт 22).


Хүснэгт 24. ТБНС-ний ЦЭХ-ний үйлдвэрлэл (сая кВт.ц)

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024
1	Импортын биет хэмжээ (сая.кВт.ц)	332.81	509.56	731.94	1,088.35
2	Дотоодын нийт үйлдвэрлэсэн ЦЭХ-ний биет хэмжээ (сая.кВт.ц)	6,574.08	6,798.27	7,154.75	7,279.94
3	Нийт	6,906.89	7,307.83	7,886.69	8,368.29

Эх үүсвэр: ЭХЗХ-ны мэдээлэл

2.39. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний ЦЭХ-ний борлуулсан дундаж үнэ тариф 2024 онд 221.94 төг/кВт.ц байгаагийн 27.86 төг.кВт.ц нь импортлолсон цахилгааны нэгжийн өртөг байна. Өөрөөр хэлбэл, ЦЭХ-ний нэгжийн өртөгт дотоодын эх үүсвэрээр үйлдвэрлэх, дамжуулах, түгээх ЦЭХ-ний нэгжийн өртөг нь 87.4 хувь, импортлолсон ЦЭХ-ний нэгжийн өртөг нь 12.6 хувийн нөлөөлөл үзүүлсэн байна (Дүрслэл 13, Хавсралт 3).

Дүрслэл 146. ТБНС-ний борлуулсан дундаж үнэ тариф болон импортын төлбөрийн харьцуулалт



Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.40. Импортоор авсан ЦЭХ-ний биет хэмжээ, төлбөрийн дүн нэмэгдэж байгаа нь эрчим хүчний хараат бус байдал хангагдахгүй байх, ЦЭХ-ний нэгжийн өртөгт импортын төлбөрийн нөлөөг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Алслагдсан бүс нутгийн эрчим хүчний дэд бүтэц хангалтгүй байгаагаас шалтгаалсан үнэ тарифын алдагдал үүсэж, улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлж байна.

2.41. Төрийн өмчийн ТЗЭ-дэд 2024 онд олгосон 61.3 тэрбум төгрөгийн татаасын 41.3 тэрбум төгрөг буюу 94.7 хувийг ББЭХС ТӨХК-д олгожээ. Тус бүсийн хувьд 2024 онд ЦЭХ-ний нийт үйлдвэрлэлийн 80.2 хувийг, 1 кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 176.57 төгрөгөөр ОХУ, БНХАУ-аас импортоор авч байна.

2.42. Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хувьд 2024 онд импортоор худалдан авсан ЦЭХ-ний үнэ тариф дээр дотооддоо үйлдвэрлэх, дамжуулах, түгээхэд гарах зардлыг шингээхэд 1 кВт.ц ЦЭХ-ний нэгжийн өртөг 351.38 төгрөг болж байхад хэрэглэгчдэд 1 кВт.ц ЦЭХ-ийг 186.57 төгрөгөөр борлуулж байна (Хавсралт 2).

2.43. Энэ 1 кВт.ц ЦЭХ тутам дахь 164.81 төгрөгийн зөрүү нь тухайн бүсийг үнэ тарифын алдагдалтай ажиллаж, улсын төсвийн татаасыг 39.1 тэрбум төгрөг буюу 94.7 хувьд хүргэхэд нөлөөлсөн байна (Хавсралт 2).

2.44. Мөн АУЭХС-ийн хувьд 2024 онд ЦЭХ-ний нэгжийн өртөг нь 239.91 төг/кВт.ц байхад хэрэглэгчдэд борлуулсан дундаж үнэ тариф 187.41 төгрөг байгаа нь 1 кВт.ц ЦЭХ тутамд 52.5 төг/кВт.ц үнэ тарифын алдагдлыг бий болгож байна (Хавсралт 2).

2.45. Эдгээр бүс дэх 1 кВт.ц ЦЭХ-ний үнэ тарифын зөрүүгээр үүсэх санхүүгийн алдагдлыг улсын төсвийн татаасаар нөхөж байна. Тухайлбал, 2024 оны улсын төсвийн нийт татаас үзүүлэх алдагдлын нөлөөллийг 67.4 хувь болоход нөлөөлж, 2021 онтой харьцуулахад 2.1 дахин өссөн байна (Хүснэгт 17).

2.46. Мөн орон нутгийн өмчийн 11 дулааны станц нь дулааны эрчим хүчийг дангаар үйлдвэрлэж байна. Тус ТЗЭ-ийн хэрэглэгчдэд борлуулж буй дулааны үнэ тариф болон бодит өртөг, зардлын зөрүүнээс үүсэх алдагдлын хэмжээг зохих түвшинд хөнгөлөх зорилгоор 2024 онд 20.0 тэрбум төгрөгийн татаасыг улсын төсвөөс олгосон байна. Энэ нь 2021 онтой харьцуулахад 3.8 дахин нэмэгдсэн байна (Хүснэгт 23).

Хүснэгт 255. Улсын төсвөөс олгосон татаас (тэрбум.төг, хувь)

№	Үзүүлэлт	Улсын төсвөөс олгосон татаас (гүйцэтгэлээр)							
		2021		2022		2023		2024	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Төрийн өмчийн 2 ТЗЭ (цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх)	19.2	78.3%	24.8	73.2%	24.3	62.3%	41.3	67.4%
2	ББЭХС ТӨХК	16.7	87.0%	23.0	92.7%	23.0	94.7%	39.1	94.7%
3	АУЭХС ТӨХК	2.5	13.0%	1.8	7.3%	1.3	5.3%	2.2	5.3%
4	Орон нутгийн өмчийн 11 ТЗЭ (дулааны станц)	5.3	21.7%	9.0	26.8%	14.7	37.7%	20.0	32.6%
	Нийт	24.5	100%	33.8	100%	39.0	100%	61.3	100%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийн ЦЭХ-ний хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглээнд олгож буй 50 хувийн хөнгөлөлт нь тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

2.47. Хот, суурин газрын агаарын бохирдлыг багасгах зорилгоор Улаанбаатар хотын болон аймгийн төв, зарим сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагийн ЦЭХ-ний хэрэглээний хөнгөлөлтийг хүйтний улиралд холбогдох тогтоол журмын дагуу үзүүлж байна¹⁶ (Дүрслэл 14).

2.48. Хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хот болон аймгийн төв, зарим сум, суурин газрын гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэхээр Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журмыг баталсан

2.49. ЭХЗХ-ны "Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай" тогтоолоор шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 100 хувийн хөнгөлөлт үзүүлж, нэмээд нэг сарын хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглэсэн цахилгааны тарифыг 50 хувиар хөнгөлөхөөр шийдвэрлэсэн нь Засгийн газрын тогтоолоор баталсан журамд хамаарахгүй хөнгөлөлт гэж үзэж, хүчингүй болгох саналыг ЭХЯ-аас ирүүлсэн ч шийдвэрлээгүй байна¹⁷.

Дүрслэл 157. Гэр хорооллын айл өрхөд ЦЭХ-ний тарифын хөнгөлөлт үзүүлэх зураглал

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨНГӨЛӨЛТИЙН ХАМРАХ ХҮРЭЭ				
Хамрах өрх	Улаанбаатар хотын гэр хорооллын 2 тарифт айл өрх	Сарын хэрэглээний дээд хязгаар	220В хүчдлийн түвшинтэй өрхийн 1 сарын хэрэглээ >700 квт.ц	100% хөнгөлөх (Засгийн газрын тогтоол)
			380В хүчдлийн түвшинтэй өрхийн 1 сарын хэрэглээ > 1500 квт.ц	
	Аймгийн төв, 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын 2 тарифт айл өрх		220В хүчдлийн түвшинтэй өрхийн 1 сарын хэрэглээ < 700 квт.ц	50% хөнгөлөх (ЭХЗХ-ны тогтоол)
			380В хүчдлийн түвшинтэй өрхийн 1 сарын хэрэглээ < 1500 квт.ц	
Хамрах хугацаа	ХҮЙТНИЙ САРУУД (11, 12, 1, 2, 3 дугаар сар) 2021-2024 оны 12 сар хүртэл: Орой, шөнийн цаг (21-06 цаг)			

Эх сурвалж: Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын хавсралт, 2020 оны 115 дугаар тогтоол, ЭХЗХ-ны 2021 оны 487 дугаар тогтоол, 2022 оны 598 дугаар тогтоол, 2023 оны 724 дүгээр тогтоол, 2024 оны 749 дүгээр тогтоол

2.50. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнэ тарифын хөнгөлөлтөд сүүлийн 4 жилд давхардсан тоогоор 710.8 мянган гэр хорооллын айл өрх хамрагдаж, хэрэглэсэн 974.4 сая.кВт.ц ЦЭХ-ний төлбөрт 109.2 тэрбум төгрөгийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээс олгожээ. Үүнээс 779.0 сая.кВт.ц ЦЭХ-ний төлбөр буюу 99.5 тэрбум төгрөгийг 100 хувь, 195.5 сая.кВт.ц ЦЭХ-ний төлбөр 9.7 тэрбум төгрөгийг 50 хувиар хөнгөлжээ.

¹⁶ Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоол "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам", 2020 оны 115 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлт

¹⁷ Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн а/88 дугаар албан бичиг

Хүснэгт 26. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнэ тарифын хөнгөлөлтөд хамрагдсан айл өрх, хэрэглээ, хөнгөлөлтийн дүн

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	Нийт
1	Хөнгөлөлтөд хамрагдсан айл өрхийн тоо (мянга)	156.0	170.3	182.3	202.2	710.8
2	Орой, шөнийн хэрэглээ (сая.кВт.ц)	217.6	231.0	240.7	285.1	974.4
3	100% хөнгөлөлт (сая.кВт.ц)	174.8	186.4	193.5	224.2	779.0
4	50% хөнгөлөлт (сая.кВт.ц)	42.8	44.6	47.3	60.8	195.5
5	Хөнгөлөлтийн дүн (НӨАТ орсон) (тэрбум.төг)	23.6	25.3	26.3	33.9	109.2
6	100% хөнгөлөлт (тэрбум.төг)	21.5	23.1	24.0	30.8	99.4
7	50% хөнгөлөлт (тэрбум.төг)	2.1	2.2	2.3	3.1	9.7

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.51. Тус хөнгөлөлтөд сүүлийн 4 жилд хамрагдсан нийт айл өрхийн 69.6 хувь буюу дийлэнх нь ТБНС-ний айл өрх бөгөөд хэрэглэсэн ЦЭХ-ний 79.9 хувь, хөнгөлөлтийн 78.6 хувийг тус тус эзэлж байна.

2.52. УБЦТС ТӨХК-ийн 2024 оны мэдээллээр тус хөнгөлөлтөд хамрагдсан айл өрхийн 1,501 кВт.ц-аас дээш хэрэглээтэй айл өрх нь 14.7 хувийг эзэлж байгаа бол бага хэрэглээтэй өрхийн сарын дундаж хэрэглээнээс 11.5 дахин их байна.

Хүснэгт 27. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн хөнгөлөлтөд хамрагдсан хэрэглэгч, 2024 он

№	Үзүүлэлт	Хэрэглэгчийн тоо*		Нийт хэрэглээ* (сая кВт.ц)	1 өрхийн сарын дундаж хэрэглээ* (кВт.ц)	Хөнгөлөлтийн дүн*	
		(Тоо)	(Хувь)			(Сая.төг)	(Хувь)
1	1500 кВт.ц хүртэлх хэрэглээ	107,323	85.3%	71.42	665.52	8,510.34	38.2%
2	1501 кВт.ц-аас дээш хэрэглээ	18,423	14.7%	140.82	7,643.65	13,776.17	61.8%
	Нийт*	125,746	100%	212.24	-	22,286.51	100%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Тайлбар: *- УБЦТС ТӨХК-ын 2024 оны 11, 12, 1, 2, 3 дүгээр сарын мэдээлэл

2.53. Дээрх хүснэгтээс харахад 125,746 хэрэглэгчид хөнгөлөлт хамрагдсанаас 14.7 хувь буюу өндөр хэрэглээтэй айл өрх нь нийт хөнгөлөлтийн 61.8 хувийг эзэлж байна.

2.54. Энэ нь ЭХЗХ-ны Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагийн хэрэглээний дээд хязгаараас давсан хэрэглээтэй айл өрхийн хэрэглээг 50 хувиар хөнгөлж байгаа нь тооцоо, судалгаанд үндэслээгүй, энэ нь улсын төсвөөс санхүүжүүлж буй эрчим хүчний салбарын татаасын хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.55. Агаар бохирдуулах бодисын 2021-2024 оны жилийн дундаж агууламжийг Агаарын чанарын стандартын хүлцэх хэмжээ¹⁸-тэй харьцуулахад PM2.5 тоосонцор хүлцэх хэмжээнээс 2.1 дахин, хүхэрлэг хий (SO2) 20.0 хувиар, PM10 тоосонцор 3.5 дахин илүү байна. Харин азотын давхар исэл (NO2) нь 40 мкг/м3 стандартын хүлцэх хэмжээндээ байна.

2.56. Засгийн газрын 199 дугаар тогтоолоор “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг баталсан¹⁹. Тус журмын зорилго нь агаарын бохирдлыг бууруулах зорилготой хэдий ч агаар бохирдуулах бодисуудын жилийн дундаж агууламж 2021-2024 онуудад хүлцэх хэмжээнээс их байгаа нь тус журмын зорилго, үр нөлөөг үнэлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

¹⁸ Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.9-д “хүлцэх хэмжээ” гэж химийн хорт болон аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх хамгийн дээд агууламжийг хэлнэ гэж тодорхойлсон.

¹⁹ Засгийн газрын 155 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.

Хүснэгт 28. Агаар бохирдуулах бодисын жилийн дундаж агууламж

№	Агаар бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)-ын хүлцэх хэмжээ	Жилийн дундаж агууламж (мкг/м3)				2021-2024 оны дундаж (мкг/м3)	2021-2024 оны дундаж агууламж болон хүлцэх хэмжээний харьцуулалт
			2021	2022	2023	2024		
1	PM2.5 тоосонцор	20	44	41	41	45	42.8	213.8%
2	Хүхэрлэг хий (SO2)	50	66	63	56	55	60.0	120.0%
3	PM10 тоосонцор	25	89	88	82	88	86.8	347.0%
4	Азотын давхар исэл (NO2)	40	36	40	39	45	40.0	100.0%

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын Агаарын чанарын хяналт-шинжилгээний 2024 оны төлөв байдлын тайлан

2.57. Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор өвлийн хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн ЦЭХ-ний төлбөрийг Засгийн газрын болон ЭХЗХ-ны шийдвэрээр олгож, аж ахуй эрхлэгчдийн хоногт хэрэглэх цахилгааны хэрэглээний дээд хязгаарыг 1м² талбай тутамд 0.768 кВт.ц хүртэл байхаар тогтоосон²⁰.

2.58. Тус хөнгөлөлтөд 2021-2024 онд 220 аж ахуй эрхлэгчид хамрагдаж, хэрэглэсэн 5.3 сая кВт.ц ЦЭХ-ний төлбөр болох 750.4 сая төгрөгийг улсын төсвийн татаасаар санхүүжүүлжээ.

Хүснэгт 29. Өвлийн хүлэмжийн хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуй эрхлэгч, хөнгөлөлтийн дүн

№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	Нийт	2024/2021	
							Тоо	Хувь
1	Хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуй эрхлэгч*	31	52	66	71	220	40	2.3**
2	Хэрэглээ (мян.кВт.ц)	942.7	1,451.4	1,569.2	1,372.5	5,335.7	429.8	145.6%
3	Хөнгөлөлтийн дүн (сая.төг)	110.3	187.7	237.4	215.0	750.4	104.6	194.8%

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

Тайлбар: *-Давхардсан тоогоор, **-дахин

2.59. Гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт (хуримтлагдсан авлага орохгүйгээр) болон Өвлийн хүлэмжийн хөнгөлөлт нь 2024 онд нийт 29.3 тэрбум төгрөгт хүрч салбарын татаас 32.3 хувийн нөлөө үзүүлсэн байна.

2.60. ЭХЗХ нь Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийг дэмжиж эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх стратегийн зорилтын хүрээнд “Хэрэглээний менежментийг сайжруулах”, “Эрчим хүчний хэмнэлтийг сурталчилна таниулах, хэрэглэгчдэд зөв дадлыг бий болгох” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ.

2.61. ЭХЗХ-ны мэдээллээр 2021-2024 онд үүрэг хүлээсэн хэрэглэгчид²¹ нь 3780 арга хэмжээ хэрэгжүүлэхэд 230.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 93.5 сая. кВт.ц ЦЭХ, 187.7 мян.Гкал ДЭХ-ний хэмнэлтийг хийх боломжийг бүрдүүлэн ажиллажээ.

²⁰ ЭХЗХ-ны 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 483 дугаар тогтоолоор баталсан.

²¹ Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 3.1.8-д “Үүрэг хүлээсэн хэрэглэгч” гэж эрчим хүчний хэрэглээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс давсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон.


Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрийн гарааны үнийг ТЭЗҮ-д үндэслэн тогтоож байгаа нь ЦЭХ-ний үнэ тарифыг бодитой тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.62. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль нь 2007 онд батлагдсан бөгөөд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хэрэглэгчдэд хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулж, 2015, 2019 онд тус тус нэмэлт өөрчлөлт орсон.

2.63. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1²²-д сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр ангилан 1 кВт.ц цахилгаан эрчим хүчийг нэгдсэн сүлжээнд худалдан авах тарифын хязгаарыг (2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн өөрчлөлт) дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.085 ам.доллар хүртэл;
- 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам.доллар;
- нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.12 ам.доллар хүртэл.

Дүрслэл 168. Монгол Улсын болон СЭХ-ний СХЧ-ын үзүүлэлт (МВт)




Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл /Бөөрөлжүүтийн 150 МВт-ын цахилгаан станц ашиглалтад орсон/

2.64. Монгол Улсын ЦЭХ-ний нийт суурилагдсан хүчин чадал 2024 онд 1,814.4 МВт байгаагаас 336.84 МВт буюу 18.6 хувийг СЭХ-ний эх үүсвэр эзэлж байна.

2.65. Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 2015 оны 299 дүгээр тогтоолоор “Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бие даасан цахилгаан (дулаан) эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг тооцох аргачлал”-ыг баталсан.

²² 11.1.Дамжуулах сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо дараахь хязгаарын хүрээнд тогтооно

Дүрслэл 179. СЭХ-ний гэрээний гарааны үнийг тооцох аргачлал дахь тарифын бүтцийн зураглал



Эх сурвалж: Аудитын баг

2.66. Сэргээгдэх эрчим хүчний ТЗЭ нь ЦЭХ-ний үнэ тарифын саналыг аргачлалын 5.3-д заасны дагуу тооцоолон саналаа ирүүлж байна. Харин батарей хураагуурын станцын тарифыг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй боловч СЭХ-ний эх үүсвэрүүдтэй адилтган гарааны үнэ тарифыг тогтоож байгааг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 30. Төвийн бүсийн СЭХ-ний баталсан гарааны үнэ тариф болон одоогийн хуулийн үнийн харьцуулалт

№	СЭХ-ний үйлдвэрлэх ТЗЭ-ийн нэр	Станц нэр	1 кВт/ц баталсан тариф 2007 он /ам.доллар.кВт.ц/	СЭХ тухай хуулийн 2019 оны өөрчлөлт /ам.доллар.кВт.ц/	Тарифын зөрүү /ам.доллар.кВт.ц/
1	Клин энерги ХХК	Салхит СЦС	0.095	0.085	0.010
2	Клин энерги Ази ХХК	Цэций СЦС	0.094	0.085	0.009
3	Сайншанд салхин парк ХХК	Сайншанд СЦС	0.095	0.085	0.010
4	Соларповер интернэйшнл ХХК	Нар НЦС	0.165	0.12	0.045
5	Эвридэй ферм ХХК	Моннаран НЦС	0.173	0.12	0.053
6	Нарантээг ХХК	Гэгээн НЦС	0.153	0.12	0.033
7	И Эс Би Солар Энержи ХХК	Сүмбэр НЦС	0.173	0.12	0.053
8	Тэнүүн гэрэл констракшн ХХК	Бөхөг НЦС	0.162	0.12	0.042
9	Дезерт солар пауэр вуан ХХК	Говь НЦС	0.142	0.12	0.022
10	Соларповер монголиа ХХК	Эрдэнэ НЦС	0.12	0.12	0.000
11	Улаанбаатар энерги ХХК	Багануур БХС	0.1565	-	-

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.67. Сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станцын гарааны үнийн хязгаарыг 2007 онд батлагдсан “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”-аар тогтоосныг 2019 онд бууруулан өөрчлөлт оруулсан ч үнэ тарифыг шинэчлэн тогтоогоогүй байгаа нь хуулиар тогтоосон үнэ тарифаас 0.022-0.06 ам.доллараар өндөр байна.

2.68. Олон Улсын судалгаагаар НЦС-ын 1 МВт-ын хөрөнгө оруулалтын хэмжээ 2023 онд 2010 оноос буурч 758.0 мянган доллар болсон нь 1 кВт.ц үнэ тариф 0.044 ам.доллар болж буурсан байгаа нь өнөөгийн Монгол улсад мөрдөгдөж байгаа үнэ тарифаас 3.5 дахин доогуур байна.

Хүснэгт 31. Олон улсын болон Монгол улсын СЭХ-ний хөрөнгө оруулалтын, үнэ тарифын харьцуулалт

Олон Улсын СЭХ-ний дундаж хөрөнгө оруулалтын үнэ болон тариф кВт.ц							
№	Хөрөнгө оруулалтын өөрчлөлт мянган ам.доллар.МВт				Дундаж үнэ тариф ам.доллар.кВт.ц		
1		2010	2023	Өөрчлөлт %	2010	2023	Өөрчлөлт %
2	НЦС	5,310.0	758.0	-86%	0.460	0.044	-90%
3	СЦС	2,272.0	1,160.0	-49%	0.111	0.033	-70%
Монгол Улсын СЭХ-ний станцын мэдээлэл							
1	Дундаж хөрөнгө оруулалт мянган ам.доллар.МВт				Дундаж үнэ тариф ам.доллар.кВт.ц/2017-2024 он/		
2	НЦС	1,668.3			0.1554		
3	СЦС	2,355.9			0.0946		

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл, IRENA (2024), Renewable power generation costs in 2023

2.70. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн ЦЭХ-ний гарааны үнэ тарифыг тогтоохдоо тухайн төслийн хөрөнгө оруулалтын хэмжээг ТЭЗҮ-д тусгасан дүнгээр тооцож байна. Харин тухайн СЭХ-ний төслийн бодит хөрөнгө оруулалт нь гарааны үнэ тариф тооцсон ТЭЗҮ дэх хөрөнгө оруулалтын хэмжээнээс зөрүүтэй байна.

2.71. Эрчим хүчний зохицуулах хорооны дотоод аудитын газраас СЭХ-ний ТЗЭ-дэд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн нийлүүлэх тарифын зохицуулалтад 2019 онд хийсэн аудитын тайлангаар бодит байдалд нийцүүлэн үнэ тариф болон түүний мөрдөх хугацааг шинэчлэх зөвлөмжийг өгсөн ч тус зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна (Хүснэгт 15).

Хүснэгт 32. ЭХЗХ-ны дотоод аудитын дүгнэлт

№		Гэрээний хугацаа /жил/		ЦЭХ нийлүүлэх үнэ тариф /ам.доллар.кВт.ц/	
		Тариф баталсан үеийн хугацаа	Бууруулах боломжит хугацаа /зөвлөмж/	Тариф баталсан үеийн	Бууруулах боломжит тариф /зөвлөмж/
1	"Эвридэй ферм" ХХК	20	7	0.173	0.12
2	"Соларповер интернэйшнл" ХХК	20	11	0.165	0.09

Эх сурвалж: ЭХЗХ-ны дотоод аудитын тайлан

2.72. Энэ нь ЭХЗХ-ны 2023 оны 725 дугаар тогтоолоор баталсан "Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм"²³-ын 6.1.12.9²⁴ дэх заалтыг зөрчиж байсан байна.

2.73. Монгол Улс, Япон Улсын Засгийн газрын хооронд "Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл"-ийн баримт бичгийг 2013 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр байгуулж, уг хамтын ажиллагааны хүрээнд СЭХ-ний станцуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Тухайлбал:

- "Эвридэй ферм" ХХК-н Моннаран НСЦ-д 6.9 сая ам.доллар;
- "Соларповер интернэйшнл" ХХК-н Нар НЦС-д 6.4 сая ам.доллар;
- "Тэнүүн гэрэл констракшн ХХК"-д 4.6 сая ам.доллар.

Хүснэгт 33. Санхүүгийн дэмжлэг авсан СЭХ үйлдвэрлэх ТЗЭ-дийн хөрөнгө оруулалт

№	СЭХ-ний үйлдвэрлэх ТЗЭ-ийн нэр	Хүчин чадал МВт	Гарааны үнэ тариф тогтоосон ТЭЗҮ дэх ХО-ын хэмжээ (сая.доллар)	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, (сая.доллар)	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс авсан буцалтгүй тусламж (сая.доллар)	Бодит хөрөнгө оруулалт /Буцалтгүй тусламжийг хассан дүнгээр/ (сая.доллар)
1	Соларповер интернэйшнл ХХК	10	14.6	19.6	6.9	12.7
2	Эвридэй ферм ХХК	12	18.3	19.4	6.4	13.0

²³ ЭХЗХ-ны 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

²⁴ Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахаас өмнө сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барих хөрөнгө оруулалтын явцын тайлан, бодит гүйцэтгэл болон "Хамтарсан кредит олгох механизм", "Цэвэр хөгжлийн механизм" зэрэг олон улсын хөнгөлөлттүүдийн орлоготой уялдуулан нээгдсэн сүлжээнд нийлүүлэх тарифын саналыг барилга угсралтын ажил дууссаны дараа ирүүлэх;

3	Тэнүүн гэрэл констракшн ХХК	15	24.8	26.4	4.6	21.8
	Нийт	37	57.7	65.4	17.9	47.5

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.74. Дээрх санхүүгийн дэмжлэг нь Гарааны үнэ тариф тогтоосон ТЭЗҮ дэх төслийн хөрөнгө оруулалтын зардалд өөрчлөлт оруулж байна (Хүснэгт 9). Ингэснээр СЭХ үйлдвэрлэх ТЭЗ-дэд ногдох хэмжээгээр үйл ажиллагааны бус орлого нэмэгдэх, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацааг богиносгох, ЦЭХ-ийг нийлүүлэх үеийн үнэ тарифыг багасгах зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн ч ашиглаагүй байна.

Салхин цахилгаан станцын хяналтыг бүрэн хэрэгжүүлж чадахгүй, эрчим хүчний салбарт гарах үр ашиг болон салбарын алдагдлыг бууруулах боломжийг алдаж байна.

2.75. ЭХЯ болон ЭХЗХ-ны холбогдох чиглэл өгсөн албан тоотын дагуу ДҮТ нь “Клин Энержи” ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах гэрээнд 2020 онд өөрчлөлт оруулж, нэгдсэн сүлжээнд нийлүүлэх тариф тооцох үеийн 116.0 сая.кВт.ц ЦЭХ-ийг 164.0 сая.кВт.ц буюу 41.4 хувиар нэмэгдүүлэн өөрчлөлт оруулсан нь тооцоо, судалгаанд үндэслээгүй байна.

2.76. Түүнчлэн ЭХЗХ нь 2021-2024 онд “Клин энержи Ази” ХХК, “Сайншанд салхин парк” ХХК-ийн ЦЭХ-ний жилд нийлүүлэх биет хэмжээг “Худалдах, худалдан авах гэрээ”-ний нэмэлт өөрчлөлтгүйгээр 331.15 сая.кВт.ц-аар нэмэгдүүлэн баталсан нь салбарт 100.1 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөгөө болсон байна.

2.77. Диспетчерийн үндэсний төв ТӨХХК 2021-2024 онд дээрх 3 СЦС-ын диспетчерийн зохицуулалт хийхдээ ЦЭХ-ний биет хэмжээг батлагдсан төлөвлөгөөнөөс 105.87 сая кВт.ц нэмэгдүүлэн авсан нь мөнгөн дүнгээр 31.9 тэрбум төгрөгийн Эдийн засгийн үр ашиггүй диспетчерийн зохицуулалт хийсэн байна (Хүснэгт 17).

Хүснэгт 34. Төвийн бүсийн СЦС-ын ЦЭХ үйлдвэрлэгчийн биет хэмжээг нэмэгдүүлсэн байх тооцоолол

№	СЭХ-ний үйлдвэрлэх ТЭЗ-ийн нэр	Станцын нэр	2021-2024			Төлөвлөгөө болон анхны тариф тооцсон ЦЭХ-ний зөрүү сая.кВт.ц	ЦЭХ -ний гүйцэтгэл болон төлөвлөгөө зөрүү сая.кВт.ц
			Анхны тариф тооцсон ЦЭХ-ний биет хэмжээ сая.кВт.ц	Баталсан ЦЭХ-ний төлөвлөгөө сая.кВт.ц	Нийлүүлсэн ЦЭХ-ний хэмжээ /гүйцэтгэл/ сая.кВт.ц		
1	Клин энержи ХХК	Салхит СЦС /50 МВт	464.00	656.00	631.55	192.00	(24.45)
2	Клин энержи Ази ХХК	Цэций СЦС/50 МВт	553.70	650.98	727.13	97.28	76.15
3	Сайншанд салхин парк ХХК	Сайншанд СЦС/55 МВт	646.80	688.67	742.84	41.87	54.17
Нийт			1,664.50	1,995.65	2,101.52	331.15	105.87

Эх сурвалж: ЭХЗХ, ДҮТ ТӨХХК-ийн мэдээлэл

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нэмэгдсэнээр дэмжих тариф өсөж, хэрэглэгчийн тарифт шууд нөлөөлж байна.

2.78. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2²⁵-д заасанчлан СЭХ үйлдвэрлэсэн үнийн зөрүүг дэмжих тарифаар тооцож байна. СЭХ-ний дэмжих тарифыг 2024 оны 11 сард баталсан цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд борлуулах шаталсан бүтэцтэй үнэ тарифт багтаасан.

²⁵ Энэ хуулийн 11.1-д заасан үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгоно.

2.79. Ингэснээр хэрэглэгчдийг дэмжих тарифт²⁶ хэдэн төгрөгийг төлж байгаа мэдээллийг авах боломжийг хязгаарлаж байна.

Хүснэгт 35. УБЦТС ТӨХК-ийн хэрэглэгчийн ЦЭХ-ний төлбөрийн нэхэмжлэл

Цахилгаан өртгийн талаар хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл				
№	Төлбөрийн үзүүлэлт	Хэрэглэгчдэд худалдаж буй ЦЭХ-ний өртөг төг/кВт.ц	Хэрэглээ кВт.ц	Мөнгөн дүн /төг/
1	Түлш, нүүрсний зардал	45.40	246.00	11,168.40
2	Үйлдвэрлэлийн зардал	129.40		31,832.40
3	Импортын зардал	23.60		5,805.60
4	Дамжуулалтын зардал	54.70		13,456.20
5	Түгээлт, хангалтын зардал	26.90		6,617.40
6	Нийт өртөг, зардал	280.00		68,880.00
7	НӨАТ 10 (%)	28.00		6,888.00
8	Өртгөөр тооцсон нийт төлбөр	308.00		75,768.00

Эх сурвалж: Хэрэглэгчийн баримтын мэдээлэл

2.80. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 2024 онд хэрэглэгчдэд борлуулсан ЦЭХ-ний 1 кВт.ц тутамд дэмжих тариф 22.53 төгрөг буюу дундаж борлуулсан тарифын 10.05 хувийг эзэлж байна.

Хүснэгт 36. СЭХ-ний дэмжих тарифын гүйцэтгэл болон дундаж тарифт эзлэх хувь

№	СЭХ-ний дэмжих тариф	2021	2022	2023	2024	2024/2021	
						Зөрүү	Хувь
1	Борлуулсан дундаж үнэ тариф /төг кВт.ц/	176.51	180.22	218.05	224.14	47.63	26.98
2	Мөрдөгдөж буй дэмжих тариф /төг кВт.ц/	23.79	23.79	23.79	23.79	-	-
3	Гүйцэтгэлээр /төг кВт.ц/	25.48	25.93	24.36	22.53	(2.95)	(11.58)
4	Борлуулсан дундаж тарифт эзлэх дэмжих тарифын хувь	14.44%	14.39%	11.17%	10.05%	(0.04)	(30.40)
5	Дэмжих тарифын орлого /тэрбум төгрөг/	151.1	163.1	170.4	167.7	16.6	11.00

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

2.81. Дэмжих тарифыг СЭХ-ний ТЗЭ бүрээр тогтоох ба хэрэглэгчдэд борлуулах дундаж үнэ тариф болон тухайн СЭХ үйлдвэрлэх ТЗЭ-ийн батлагдсан тарифын зөрүүнээс үүсэх хэмжээг тухайн жилийн НХЗ-ын нийт борлуулах ЦЭХ-ний биет хэмжээнд уялдуулан тооцсон байна. Дэмжих тарифын нэгжийн үнэ гүйцэтгэлээр жил бүр буурсан боловч нийт дэмжих тарифын орлого 2024 оныг 2021 онтой харьцуулахад 16.6 тэрбум төгрөг буюу 11 хувиар өссөн байна.

2.82. Харин 2024 оны байдлаар ЭХЗХ-оос 24 ААН-ын 1111 МВт хүчин чадалтай СЭХ-ний барилга байгууламж барих ТЗЭ олгосон байна. Цаашид СЭХ-ний эх үүсвэрүүд ашиглалтад орсноор дэмжих тарифын өсөлтөд шууд нөлөөлөхөөр байна.

Хүснэгт 37. ЭХБББ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэрэглэгчийн тарифт үзүүлэх нөлөөлөл

№	ЭХБББ	СХЧ	Цахилгаан түгээлт	ЦЭХ худалдах дундаж тариф	СЭХ-ний үйлдвэрлэл-ийн өртөг	Хэрэглэгчийн тарифт үзүүлэх нөлөө
1	Хэмжих нэгж	МВт	мян. кВт.ц	төг/кВт.ц	сая төг	төг/кВт.ц
2	Нарны цахилгаан станц	140.0	94,950.5	468.82	44,514.8	4.39
3	Салхин цахилгаан станц	252.0	861,247.8	303.69	261,548.5	20.49
4	Усан ЦС болон Усан цэнэгт ЦС	412.6	1,231,971.1	328.55	404,758.6	38.73
5	Биомасс	61.4	277,393.1	370.94	102,897.3	8.03
6	Эрчим хүч хуримтлуурын систем	245.0	171,202.2	464.74	79,564.8	9.23
	Нийт	1,111.0	2,636,764.8	338.78	893,284.0	80.88
						Мөрдөж буй дэмжих тариф, төг/кВт.ц
						Дэмжих тариф өөрчлөгдөх дүн, төг/кВт.ц
						104.67

Эх сурвалж: ЭХЗХ-ны мэдээлэл

²⁶ Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9.-д "дэмжих тариф" гэж сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг хэлнэ гэж тодорхойлсон.

2.83. Дээрх СЭХ-ний эх үүсвэрүүд ашиглалтад орж НХЗ-д ЦЭХ нийлүүлж эхэлснээр дэмжих тариф 80.88 төг кВт.ц-аар нэмэгдэж ЦЭХ-ний үнэ тарифт 104.67 төг кВт.ц-аар шууд нөлөөлөхөөр байна.

Цахилгаан, дулааны эрчим хүчний тарифын арга зүй, суурь тооцоог ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

2.84. Эрчим хүчний зохицуулах хороо 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр баталсан цахилгаан, дулааны эрчим хүчний шаталсан бүтэцтэй үнэ тарифын тогтоолуудад “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ыг үндэслэл болгон ашиглаагүй нь холбогдох аргачлалын дагуу тооцоо, судалгаа хийгдсэн гэх нотолгоог үгүйсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.85. Нэгдсэн сүлжээнд холбогдсон айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг бүс нутгийн (Төв, Өмнөд, Алтай-Улиастай, Зүүн бүс) ялгаа, тоолуурын төрөл (энгийн, хоёр тарифт, гурван тарифт), хэрэглээний хэмжээ (150 кВт.ц хүртэл, 150–300 кВт.ц, 300 кВт.ц-аас дээш) болон хэрэглээний цагийн хуваарийн дагуу шаталсан бүтэцтэйгээр тогтоосон байна.

2.86. Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлалд шаталсан бүтэцтэй тарифын агуулга, ойлголт, тодорхойлолт, томьёо тусгагдаагүй нь аргачлал болон бодит тооцооны хооронд зөрүү үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.87. Мөн тус аргачлалд үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын салбарын ангиллыг тусгаагүй боловч баталсан тарифт уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч ТЗЭ, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж гэж оруулсан нь тооцоо, мэдээлэл болон аргачлалын зөрүүтэй байдлыг бий болгох нөхцлийг бүрдүүлж байна.

2.88. Эрчим хүчний зохицуулах нь Нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифын нөлөөллийн шинжилгээг хийж, 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 01/545 дугаар албан бичгээр “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд” бүртгүүлэх хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2.89. Нөлөөллийн шинжилгээний үр дүнгээс харахад цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифын тогтоолын төслийг Хорооны цахим хуудсанд 2024 оны 2 дугаар сарын 9-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байршуулсан боловч тухайн өөрчлөлттэй холбоотой танилцуулга, судалгаа, шинжилгээний үр дүн, иргэд болон байгууллагуудаас ирүүлсэн санал зэргийг нээлттэй нийтлээгүй байгаа нь үнэ тарифын өөрчлөлтийн талаарх мэдээллээр хэрэглэгчдийг хангаагүйг харуулж байна.

Хэрэглэгчийн төлбөрийн өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс олон талтай, системийн болон хэрэглээний түвшний шалтгаантай болохыг харуулж байна.

2.90. Цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлттэй холбоотой хэрэглэгчдийн гомдлыг шуурхай шийдвэрлэх, зөвлөмж гаргах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор ЭХЗХ болон “УБЦТС” ТӨХК хамтран ажлын хэсгийг ЭХЗХ-ны даргын 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулжээ.

2.91. Дээрх ажлын хэсэг нь шинэчлэн баталсан цахилгаан, дулааны эрчим хүчний дундаж үнэ тарифын өөрчлөлттэй холбоотойгоор хэрэглэгчдээс ирсэн гомдлыг судалж, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлсэн.

2.92. Ажлын хэсэг нь нийт 135 хэрэглэгчийн гомдлыг судалж, тэдгээрийн 123 буюу 91.1 хувьд нь хэрэглээний өөрчлөлт, төлбөрийн өсөлтийн шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Гомдол гаргасан 122 хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээ 2025 оны 01 дүгээр сарын дунджаар 366.3 кВт.ц байсан 2024 оны 12 дугаар сарынхаас 1000 кВт.ц буюу 23.3 хувиар нэмэгдсэн тул төлбөр нь өссөн байна.
- Хэрэглэгчид цахилгааны үр ашиггүй зарцуулах, хэрэглээгээ өдөр, шөнийн цагт тохируулах дадал хэвшил бага байгаа нь хэрэглээг нэмэгдүүлсэн байна.
- Гомдол гаргасан хэрэглэгчдийн бодит нөхцөл байдалтай танилцах явцад гэр хорооллын айл өрхүүдийн сууцны дулаан алдагдал ихтэйгээс хэрэглээнийхээ 70 гаруй хувийг халаагуурт зарцуулж байна. Зарим

айл өрхийн хувьд дулаан алдагдлаа бууруулахад бус халаах хэрэгслийн чадлыг нэмэгдүүлэх хандлагатай байв.

- Хэрэглэгчдэд борлуулах ЦЭХ-ний дундаж үнэ тариф 30-аас 73 хүртэл хувиар өсөж байгааг олон нийтийн цахим сүлжээнд ЦЭХ-ний үнэ тарифыг 3-4 дахин нэмэгдсэн гэж бодит бус мэдээлэл тавигдаж байгаа нь хэрэглэгчдийг бухимдуулах шалтгааны нэг болж байна.

2.93. Иймд цахилгаан, дулааны үнэ тарифын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан тооцох, хэрэглэгчдэд мэдээлэл өгөх, хэрэглээний зөв дадал төлөвшүүлэх, ТЗЭ-ийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга стандартыг тогтоох журмыг мөрдөж, ажиллах шаардлагатай байна.

2.94. Эрчим хүчний яамны 2024 оны шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс 141 буюу 95.9 хувийг хугацаанд нь, 4 буюу 4.1 хувийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт оруулаагүй байна.

Хүснэгт 38. Эрчим хүчний яамны Шилэн дансны хуулийн хэрэгжилт

№	Тайлангийн нэр	Мэдээлэл оруулах хугацаа	Давтамж	Тайлбар
1	Дараа жилийн төсвийн төсөл (Төлөвлөгөө)	IX/15-ны дотор	1 удаа	10-р сарын мэдээллийг хугацаа хоцорч оруулсан.
2	Санхүүгийн тайлан (Гүйцэтгэл)	IV/15-ны дотор	1 удаа	Огт ороогүй
3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Гүйцэтгэл)	IV/25-ны дотор	1 удаа	Огт ороогүй
4	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Дараа сарын 8-ны дотор	12	1,6,9-р сарын мэдээллийг хоцорч оруулсан

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

2.95. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 132 мэдээллээс 126 буюу 95.5 хувийг хугацаанд нь, 5 буюу 3.8 хувийг хугацаа хоцроож, 1 буюу 0.8 хувийг оруулаагүй байна.

Хүснэгт 39. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт

№	Тайлангийн нэр	Мэдээлэл оруулах хугацаа	Давтамж	Сар	Тайлбар
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	Дараа сарын 8-ны дотор	12	3	3-р сарын мэдээлэл хугацаа хоцорсон
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл		12	3	3-р сарын мэдээлэл хугацаа хоцорсон
3	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл		12	6	6-р сарын мэдээлэл хугацаа хоцорсон
4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө	Жил бүрийн I/10-ны дотор	1	1	Огт оруулаагүй
5	Дараа жилийн төсвийн төсөл (төлөвлөгөө)	Жил бүрийн IX/15-ны дотор	1	9	9-р сарын мэдээлэл хугацаа хоцорсон
6	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (гүйцэтгэл /өссөн дүн/)	Дараа сарын 8-ны дотор	12	6	6-р сарын мэдээлэл хугацаа хоцорсон

Эх сурвалж: ЭХЯ-ны мэдээлэл

2.96. Эрчим хүчний зохицуулах хороо нь Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан. Төрийн өмчит аж ахуй нэгж дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ гэх заалтын агуулга, стандартыг мөрдөж ажиллахгүй байна.

2.97. Диспетчерийн үндэсний төв ТӨХХК -ийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 169 мэдээллээс 169 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Бодлого төлөвлөлт, бүтэц тогтолцоо, нөөцийн талаар:

- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д эрчим хүчний талаар дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгахдаа Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн 244 шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй, мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй нь салбарын хөгжиж байгаа эсэхийг хэмжих боломжгүй байна.
- Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, байгалийн нөөцийн үр ашигтай менежмент хийх, ногоон санхүүжилт татах зэрэг арга хэмжээг дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгаснаар үр дүнг тооцох, хянах нөхцөл бүрдэхээр байна.
- Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрээс доош чиглэсэн, салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн саналыг нэгтгэн доороос дээш чиглэсэн нэгдмэл уялдаа холбоотой байхаар төлөвлөх шаардлагатай байна
- Эрчим хүчний салбарын төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компаниуд нь тайлант хугацаанд эдийн засаг, санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж, зарим аж ахуйн нэгжүүдэд улсын төсвөөс татаас авч байгаа нь компанийн засаглалыг сайжруулах, гүйцэтгэх удирдлагын хариуцлага, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Дэлхийн эрчим хүчний зөвлөлөөс гаргасан түлш, эрчим хүчний асуудлыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг ахиулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч чадахгүй, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байна.
- Засгийн газар бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний зохицуулах хороог байгуулах, дүрмийг батлах, зохицуулагчийг томилж байгаа нь ЭХЗХ чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөл бүрдэхгүй байна.

Томоохон төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтийн хүрээнд:

- Эрчим хүчний яамны 2021-2024 оны нийт төсвийн 42 хувийг эрчим хүчний салбарын алдагдалд олгож буй улсын төсвийн дэмжлэг, татаас эзэлж байгаа нь томоохон төслүүдэд хийгдэх хөрөнгө оруулалт санхүүжилтэд нөлөөлж, төсөл арга хэмжээ төлөвлөгөөт хугацаанаас хоцрох, өртөг зардал нэмэгдэх шалтгаан болж байна.
- Эрчим хүчний салбарт хийгдэж буй томоохон төслийн санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, төсөл хөтөлбөрийг ач холбогдлоор нь эрэмбэлж, нөөц эх үүсвэрт үндэслэн санхүүжилтийг шийддэг тогтолцоог бий болгосноор олон талын эрх хангагдахаар байна.
- Эрчим хүчний хуримтлагдсан алдагдлаас үүдэн насжилт өндөртэй техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, шинэчлэлийн ажил удааширч, эргэн төлөгдөх эх үүсвэргүй өр, төлбөр хуримтлагдаж байгаа нь эрчим хүчний салбарын тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг алдагдуулж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байх өндөр эрсдэлтэй байна.

Сэргээгдэх эрчим хүчний бодлого, үйл ажиллагааны хүрээнд:

- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэгчдийн эрчим хүчний системд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ нэмэгдэхгүй байгаа ч эрчим хүчний системээс авах төлбөр, борлуулалтын орлого нэмэгдсэн байна.
- Сэргээгдэх эрчим хүчний гэрээний гарааны үнийг тогтоохдоо тухайн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэл, санхүүжилтийн хэлбэр, нэгдсэн сүлжээнд

нийлүүлэх ЦЭХ-ний биет хэмжээг бодитоор тооцож, холбогдох гэрээнд тусгадаггүй байна.

- Сэргээгдэх эрчим хүчний дэмжих тарифыг хэрэглэгчдэд худалдаж буй өртөгт оруулсныг төлбөрийн үзүүлэлтэд харуулаагүй нь хэрэглэгчийн мэдэх эрхийг хязгаарласан байна.
- Хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд тариф тогтоох зарчмыг баримтлан үнэ, тариф тогтоох шийдвэрийг хараат бусаар гаргах шаардлагатай байна.

Цахилгаан эрчим хүчний үнэ тариф, бодит өртөг, алдагдлын талаар:

- Эрчим хүчний үнэ тарифыг тогтооход үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах болон үнийг инфляцтай уялдуулан тооцож, тогтмол индексжүүлж батлахгүй байгаа нь эрчим хүчний салбарын алдагдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа доголдох, нөгөө талаас хэрэглэгчдэд санхүүгийн ачаалал үзүүлэх эрсдэлтэй байна.
- Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын эх үүсвэрээс хангах боломжийг нэмэгдүүлээгүйгээс импортын хэрэглээ жил бүр нэмэгдэж, цахилгаан эрчим хүчний үнэ тарифын өсөлтөд нөлөөлж байна.
- Гэр хорооллын айл өрхийн ЦЭХ-ний хэрэглээний дээд хязгаараас давсан хэрэглээнд олгож буй 50 хувийн хөнгөлөлтийг тооцоо судалгаанд үндэслээгүй байгаа нь эрчим хүчний салбарын татаасыг нэмэгдүүлж байгаа тул хөнгөлөлтийг олгохдоо тодорхой судалгаа тооцоонд үндэслэн зорилтот бүлэгт олгодог байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.
- Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийн орой болон шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг журмаар зохицуулан, хөнгөлөлтийг олгож байгаа нь эрчим хүчний салбарын татаасыг нэмэгдүүлж, үр ашиггүй байх нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлж байна.
- Цахилгаан эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн бодлоготой зөрчилдөж байгаа тул халаалтаа цахилгаанаар шийдсэн гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэгийг эрчим хүчний салбараас тусгаарлан, холбогдох салбарт хариуцуулж, эрчим хүчний салбарын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- ДҮТ ТӨХХК нь 2021-2024 онд ЭХЗХ-ны баталсан СЭХ-ний үйлдвэрлэгчдээс нэгдсэн сүлжээнд үйлдвэрлэж нийлүүлэх ЦЭХ-ний төлөвлөгөөнөөс илүү авч байсан нь цахилгаан станцуудын үйл ажиллагааны орлогыг 31.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж, салбарын санхүү, эдийн засгийн байдалд нөлөөлж байгаа тул үр ашигтай диспетчерийн зохицуулалт хийх шаардлагатай байна.
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 онд баталсан шаталсан бүтэцтэй үнэ тариф, түүний тооцооллын төрөл, ангилал, ойлголт тодорхойлолт нь “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал” -д тусгагдаагүй байгаа нь үнэ тарифыг шинжлэх ухааны үндэслэлтэй тооцсон эсэхэд эргэлзээ үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.
- Үндэсний аудитын газраас 2017, 2021 онд хийсэн аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД

- Эрчим хүчний тухай хуульд ЭХЗХ-ны чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх;
- Хэрэв үнэ тарифыг өртгөөс нь бага байлгах бодлого баримталбал эрчим хүчний салбарын алдагдлыг санхүүжүүлэх татаасыг бүрэн олгох;

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ САЙДАД

- Эрчим хүчний асуудлыг нийгэм, эдийн засаг, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг ахиулах талаар хүрэх түвшин, гарах үр дүнг тооцох нарийвчилсан төлөвлөгөөг Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэгтэй уялдуулан боловсруулж, биелэлтийг тайлагнаж ажиллах;
- Эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж, хугацаа удааширсан, санхүүжилт нэмэгдсэн шалтгаан нөхцөлийг тодруулж гүйцэтгэлийг хянах боломжтой ажлын төлөвлөгөө боловсруулах;
- Хөдөлмөрийн бүтээмжээс хамаарсан бүтэц, орон тоог тогтоох жишиг норм нормативыг тооцох аргачлалын дагуу эрчим хүчний төрийн өмчит компаниудад чиг үүргийн шинжилгээ хийж, шинжилгээний дүнд үндэслэн удирдлагын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, үйл ажиллагааны өртөг зардлыг бууруулж, эдийн засгийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм болон үйл ажиллагаанд мөрдөх баримт бичгүүдэд хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой заалтыг тусган шинэчлэх, түүнийг хэмжих, хянах үйл явцыг тодорхой болгох замаар хорооны дүрэмд заасан чиг үүргээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай;
- Үнэ тарифыг эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн тогтмол давтамжтайгаар индексжүүлдэг, хараат бус, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хуулийн хугацаанд оруулах;
- Импортын эрчим хүчний хэрэглээг бууруулах, дотоодын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг дэмжих урт хугацааны бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Эрчим хүчний аюулгүй, найдвартай байдал алдагдсан, нөөц тоноглолгүй байгаа өнөө үед эрсдэлийн үеийн төлөвлөгөө боловсруулан баталж мөрдөх;
- Эрчим хүчний салбарын тариф тооцоход ашиглаж буй норм стандартуудыг шинэчлэх, шинээр боловсруулж, батлуулах;
- Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх, инновацыг нэвтрүүлэх, техник, тоног төхөөрөмжийн насжилт, засвар үйлчилгээний талаарх тооцоо, судалгаа хийж нэн тэргүүнд шинэчлэх, засварлах шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг эрэмбэлэн санал боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэн арга хэмжээ авах;

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГАД

- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг бодит өртөгт нийцүүлэн хууль, тогтоомжид заасан үндэслэлээр тооцож шинэчлэх;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэгчтэй байгуулах эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний загварыг хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;

- Сэргээгдэх эрчим хүчний гарааны үнэ тарифыг бодит хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд үндэслэх зохицуулалтыг холбогдох эрх зүйн баримт бичигт тусган, хэрэгжилтийг ханган ажиллах;
- Зохицуулалтын аудиторыг томилсон нь эерэг алхам боловч чиг үүрэгт нь үнэ тариф тогтоох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтын зохицуулалтыг нэмж оруулах;
- Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журмын хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийж, айл өрхийн орой, шөнийн цагийн хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглэсэн цахилгааны үнэ тарифын 50 хувийн хөнгөлөлтийн гүйцэтгэлийг үнэлэх замаар хэрэгцээ шаардлага, тооцооллыг хийж, журмын зохицуулалтыг нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх ажил зохион байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн нэгдсэн сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний биет хэмжээг СЭТХ-ийн 10.2-д заасны дагуу худалдах, худалдан авах гэрээнд тусгах ажлыг зохион байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний дэмжих тарифын бүтцийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэд олон нийтэд энгийн, ойлгомжтой байдлаар таниулах;
- Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлалд шаталсан бүтэцтэй тарифын төрөл, агуулга, ангиллыг тодорхойлж, тусган шинэчлэх;
- Тарифын өөрчлөлт, аргачлал, тооцооны талаарх мэдээллийг хэрэглэгчдэд ойлгомжтой, тогтмол хүргэж, судалгаа, нөлөөллийн шинжилгээ, санал авах үйл явцыг ил тод, хүртээмжтэй болгох;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-Д

- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн нэгдсэн сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний жилд нийлүүлэх биет хэмжээг ЭХЗХ-ны тариф тооцсон үеийн биет хэмжээг худалдах, худалдан авах гэрээнд тусган оруулж хэрэгжилтийг ханган ажиллах;
- Удирдлага, мэдээллийн техник, тоног төхөөрөмжийн насжилт, үйлчилгээний талаар тооцоо судалгаа хийж шинэчлэх санал боловсруулан ЭХЯ-д хүргүүлэх;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛАНД ТУСГАСАН ТАЛААР:

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНААС ИРҮҮЛСЭН
АЛБАН БИЧИГ**



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНООС ИРҮҮЛСЭН АЛАБН БИЧИГ**



**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВӨӨС
ИРҮҮЛСЭН АЛБАН БИЧИГ**



**ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН
САНАЛ, ТУСГАСАН БАЙДАЛ**



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй
төсөл арга хэмжээ



Хавсралт 2.

1 кВт.ц ЦЭХ-ийг борлуулсан дундаж
тариф, бодит өртгийн харьцуулалт



Хавсралт 3.

Эрчим хүчний салбарын эдийн засгийн
үзүүлэлт



Хавсралт 4.

Импортын ЦЭХ-ний нэгжийн өртөг,
түүний нөлөө (дүнд эзлэх хувь)



Хавсралт 5.

ТЗЭ-дийн 2021-2024 онуудын ухаалаг
тоолуурын судалгаа



Хавсралт 6.

ЭХЗХ-ны Шилэн дансны хуулийн
хэрэгжилт



[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.